

**Дэлхийн Банк Группын баримт бичиг**

**ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД**

**Тайлангийн дугаар:132141-MN**

**ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК**

**ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦ**

**ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦ**

**ОЛОН ТАЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАТАЛГААНЫ АГЕНТЛАГ**

**МОНГОЛ УЛСТАЙ БАЙГУУЛАХ  
ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИ**

**2021-2025 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛ**

**2020 оны 12 дугаар сар - Зөвлөлдөх хэлэлцүүлгийн төсөл**

**Хятад, Монгол, Солонгос улс хариуцсан газрын менежментийн нэгж  
Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг**

**Олон Улсын Санхүүгийн Корпорац  
Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг**

**Олон Талт Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлаг**

2021-2025 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛД  
МОНГОЛ УЛСТАЙ БАЙГУУЛАХ  
ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ХҮРЭЭ

Агуулга

I. УДИРТГАЛ .....	5
II. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ .....	6
III. ДЭЛХИЙН БАНК ГРУППЫН ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИ .....	14
3.3 Чиглэл тус бүрт ДБГ-ээс үзүүлэх дэмжлэгийн зорилго .....	15
Чиглэл 1: Эдийн засгийн сэргэлт, тогтвортой байдлыг дэмжих.....	15
Чиглэл 2: Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, чанартай ажлын байр бий болгох.....	17
Чиглэл 3: Хүмүүн капиталыг өргөжүүлэх ба амьдралын чанарыг сайжруулах.....	24
3.4 Түншлэлийн стратегийг хэрэгжүүлэх.....	30
IV. ТСХ-НИЙ ХӨТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ.....	33

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн Хөгжлийн Банк
ЭЗХЗТС	Эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа
КОВИД-19	2019 онд гарсан шинэ төрлийн коронавируст халдвар
ТСХ	Түншлэлийн стратегийн хүрээ
ТС	Түншлэлийн стратеги
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн Банк
АН	Ардчилсан Нам
ХБҮА	Хөгжлийн бодлогын үйл ажиллагаа
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЗАНД	Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг
ЭЗДХ	Эдийн засгийн менежментийг дэмжих хөтөлбөр
ЕХ	Европын Холбоо
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
СЖ	Санхүүгийн жил
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОУСБХБ	Олон Улсын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк
ОУХА	Олон Улсын Хөгжлийн Ассоциац
МХХТ	мэдээлэл, харилцаа холбооны технологи
ХБҮГ	Хараат бус үнэлгээний газар
ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпорац
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОТХОБА	Олон Талт Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлаг
МАН	Монгол Ардын Нам
ЖДҮ	жижиг дунд үйлдвэр
ББСБ	банк бус санхүүгийн байгууллага
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ОТ	Оюу Толгой
ГСД	Гүйцэтгэл ба сургамжийн дүгнэлт
ТХХТ	Төр хувийн хэвшлийн түншлэл
ЦДШ	Цогц дүн шинжилгээ/оношилгоо
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилтууд
ТТ	техникийн туслалцаа
МСҮТ	мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
УБ	Улаанбаатар
ҮТХН	Үндэсний тодорхойлсон хувь нэмэр
P4R	үр дүнд суурилсан хөтөлбөр
CRW	Хямралын эсрэг хариу арга хэмжээ авах хөтөлбөр
PBA	Гүйцэтгэлд суурилсан хуваарилалт

ХОТС	Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХДК	Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорац
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ХАТХИС	Хүлээн авагч талын хэрэгжүүлэх итгэлцлийн сан
SORT	Үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх системчилсэн хэрэгсэл
ДБ	Дэлхийн Банк
ДБГ	Дэлхийн Банк Групп

## I. УДИРТГАЛ

- 1. Дэлхийн Банк Групп (ДБГ) ба Монгол Улс (1991-2021)-ын түншлэлийн 30 жилийн ой 2021 онд тохиож байна.** Түншлэлийн эхэн үед ДБГ-ээс Монгол Улсад үзүүлсэн дэмжлэгийн дийлэнх нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үйл явцыг дэмжихэд чиглэгдэж байв. Монгол Улсын гаднаас авч байсан тусламж огцом буурснаас үүдэн үндсэн дэд бүтцийг хөгжүүлэх, хувийн хэвшил, санхүүгийн болон хууль эрх зүйн шинэ тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх шаардлага бий болсон. Цаашлаад ядуурлыг бууруулах, хүний хөгжил болон хөдөөгийн амьжиргааг дэмжихэд чиглэсэн хамтын ажиллагаа жил ирэх тусам гүнзгийрэв. Сүүлийн жилүүдэд ДБГ нь уул уурхайн салбарыг хөгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, мөн 2009, 2014, 2020 оны эдийн засгийн огцом уналтын дараах эдийн засгийг тогтворжуулахад анхааран ажилласан.
- 2. ДБГ-ээс Монгол Улстай байгуулсан өмнөх стратеги болох 2013-2017 оны санхүүгийн жилийн Түншлэлийн стратеги (ТС)-ийг ДБГ-ны Захирлуудын зөвлөлөөр 2012 оны 5 дугаар сарын 7-ны өдөр хэлэлцүүлж байсан бөгөөд 2020 оны 12 дугаар сар хүртэл нийт 2 удаа сунгасан.** Энэхүү стратеги нь үндсэн гурван тулгуур чиглэлтэй байсан бөгөөд үүнд: (1) уул уурхайд тулгуурласан эдийн засгийг тогтвортой, ил тод удирдах Монгол Улсын чадавхыг сайжруулах; (2) хот, хөдөөгийн эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийн тогтвортой, төрөлжсөн бааз суурийг бий болгох; мөн (3) төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар эмзэг байдлыг шийдвэрлэх зэрэг болно. ДБГ-ээс Гүйцэтгэл ба сургамжийн 2 удаагийн дүгнэлт (ГСД) -ийг 2016 болон 2019 онд тус тус хийсэн. Хоёр удаагийн ГСД-ээр Монгол Улсад гарсан өөрчлөлт, нөхцөл байдлыг харгалзан үр дүнгийн хүрээнд тохиргоо хийж, түншлэлийн стратегийг тус тус сунгасан.
- 3. Энэхүү Түншлэлийн стратегийн хүрээ (ТСХ) нь 2021-2025 оны санхүүгийн жилийг хамрах бөгөөд 2020 оны 6 дугаар сард болсон Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын сонгуулийн дараа томилогдсон шинэ Засгийн газрын бодлого, хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан болно.** Энэхүү ТСХ-г шинээр сонгогдсон УИХ-аас баталсан Монгол Улсын үрт хугацааны хөгжлийн стратеги болох Монгол Улсын Алсын хараа - 2050, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл (2020-2025), Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024)-тэй уялдуулсан болно. ТСХ нь 2018 оны Монгол Улсын цогц дүн шинжилгээ (ЦДШ), 2020 оны Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн загварын тойм (ЭЗХЗТ) судалгаа, ТС-ийн Гүйцэтгэл ба сургамжийн дүгнэлт (ГСД), Монгол дахь оролцогч бусад талуудтай хийсэн хоёр үе шаттай зөвлөгөөн, харилцагчдын судалгаа зэрэг баримт бичиг, судалгаанд тулгуурлав.
- 4. Энэхүү ТСХ нь КОВИД-19 цар тахлын улмаас Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хүнд хохирол учирч буй эгзэгтэй мөчид боловсруулагдсан болно.** КОВИД-19 цар тахлын хямрал нүүрлэж эхлэхэд Монгол Улсын эдийн засаг 2016 оны эдийн засгийн уналтаас сэргэж байсан үе юм. КОВИД-19 цар тахлын нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө улам бүр идэвхжиж, Монгол Улсын эдийн засаг, ард иргэдийн амьжиргаанд томоохон цохилт үзүүлээд байна. Үүнээс улбаалан үйл ажиллагааны шинэ орчин бий болж, Монгол Улсын хөгжлийн зарим суурь бэрхшээлийг тодотгож байна. Монгол Улс нь богино хугацаандаа яаралтай тусламж үзүүлэх, эрүүл мэндийн салбарт тулгарч буй хүндрэлүүдэд хариу арга хэмжээ авах, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулахын зэрэгцээ хямралыг даван туулж, хөгжлийн суурь бэрхшээл, сорилтуудаа шийдвэрлэхүйц эдийн засгийн илүү тогтвортой, хүртээмжтэй, уян хатан сэргэлтийг бий болгох давхар сорилттой тулгарч байна. ТСХ нь энэхүү давхар бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн Монгол Улсын хүчин чармайлтыг дэмжих зорилгоор боловсруулагдсан болно. Энэхүү ТСХ нь Монгол Улс ОУХА-аас тусламж дэмжлэг авах улс

орны жагсаалтаас хасагдаж, 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс зөвхөн ОУСБХБ-ны зээл авах болсноос хойших анхны стратеги юм.

## II. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

5. **Монгол Улс бол нүүдлийн баялаг өв соёлтой, өргөн уудам газар нутагтай, эрс тэс үүр амьсгалтай орон юм.** Газар нутгийн хувьд ХБНГУ-ын нутаг дэвсгэрээс дөрөв дахин том, дэлхийд хүн амын нягтаршил хамгийн багад тооцогдох нийт 3.3 сая хүн хүн амтай улс юм. Далайд гарцгүй, ОХУ ба БНХАУ-ын хооронд орших бөгөөд өргөн уудам хөдөө орон нутаг нь суурь дэд бүтцээр муу холбогдсон байна. Хүн амын бараг тал хувь нь нийслэл Улаанбаатар хот болон түүний эргэн тойрны бүсэд амьдардаг бөгөөд үлдсэн хэсэг нь хотын жижиг төвүүд болон өргөн уудам тал нутгаар хонь, ямаа, адуу, үхэр, сарлаг, тэмээ зэрэг мал маллаж амьдардаг. Өвлийн улиралд ихэвчлэн цельсийн -30 хэмээс доош хүрч хүйтэрдэг. Газар тариалан, барилгын ажлын улирал богино, тариалангийн талбай нь нийт газар нутгийн талбайн дөнгөж 1 хувийг эзэлдэг тул байгалийн бүтээмж багатай. Нийт Монголчуудын бараг 30 орчим хувь нь нүүдлийн уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхэлсээр байгаа бөгөөд жилд дөрвөн удаа нүүдэллэж амьдардаг. Малчид гар утас, интернэт, орчин үеийн тээврийн хэрэгсэл, кабелийн холболттой телевизор, нарны зайн хураагуур зэрэг технологийн дэвшлийг аж амьдралдаа нэвтрүүлж, ашиглахдаа хурдан байгаа боловч мал аж ахуй нь тэдний орлогын цорын ганц эх үүсвэр тул амьжиргаа нь эмзэг хэвээр байна. Хөдөө орон нутагт ажлын олдоц, боломж хомс байдаг.

6. **Монгол Улс 1990-ээд оны эхэн үеэс зах зээлийн эдийн засаг бүхий ардчилсан засаглалын тогтолцоонд шилжсэн.** Шинэ Үндсэн хуулиа 1992 онд баталж, парламентын засаглал бүхий улс болсон. Үүнээс хойш найман удаа хууль тогтоох байгууллагын сонгууль явуулсан бөгөөд эдгээр нь бүгд чөлөөт, шударга сонгууль болсон гэж тооцогддог. Монгол Ардын Нам (МАН, өмнө нь Монгол Ардын Хувьсгалт Нам гэж нэрлэдэг байсан), Ардчилсан Нам (АН) гэсэн хоёр нам улс төрийн тавцанд давамгайлж, засгийн эрхийг ээлжлэн, зарим үед эвсэл байгуулах замаар барьж байв. УИХ-ын сүүлийн сонгууль буюу 2020 оны 6 дугаар сард болсон сонгуулиар эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөр, КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахаар ажиллаж буй эрх баригч МАН үнэмлэхүй ялалт байгуулж, улмаар УИХ дахь 76 суудлаас 62 суудлыг тус нам авсан. Ерөнхийлөгчийн суудлыг одоогоор АН авсан байгаа бөгөөд дараагийн Ерөнхийлөгчийг сонгох ээлжит сонгуулийг 2021 онд хийхээр төлөвлөж байна. Улс төр, олон нийтийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хувьд Монгол Улс өндөр үзүүлэлттэйгээс гадна 500 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл ажилладаг бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нөлөө улам бүр нэмэгдэж байна. Иргэний нийгэм нь төлөвшиж байгаа хэдий ч иргэний нийгмийн байгууллагын институцийн болон санхүүгийн чадавх сул байна. УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгчийн засаглалын эрх мэдэл, хариуцлагын хуваарилалтыг тодорхой болгох, УИХ, Засгийн газрын үйл ажиллагааг бэхжүүлэх, төсвийн сахилга бат, шүүхийн хараат бус байдлыг сайжруулах, орон нутгийн засаглалыг бэхжүүлэх зорилгоор 2019 оны 11 дүгээр сард Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.

7. **Монгол Улс ардчилалд шилжих явц гайхалтай тайван замаар өрнөсөн хэдий ч улс төрийн нөхцөл байдал цаашдаа тогтворгүй байсан.** Одоогийн Ерөнхий сайд 2017 онд томилогдохоос өмнө 1992 оноос хойших арван таван Ерөнхий сайд тус улсад дунджаар 1.5-аас доош жил эрх барьсан байгаа нь эвсэл, эрх баригч намуудын доторх тогтворгүй байдлыг илэрхийлж байна. 2017 онд болж өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Монгол Улсад анх удаа хоёрдугаар шатны санал хураалтыг явагдаж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд аль нэг талыг барих байдал ихэссэний дээр сонгогчдын 8-аас илүү хувь нь цагаан саналын хуудас (аль ч нэр дэвшигчийг сонгохгүй гэдгээ

илэрхийлсэн эсэргүүцлийн санал хураалтын хэлбэр) бөглөж байснаар онцлог байв. Агаарын бохирдол, авилга, төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой оффшор дансыг илчлэх, ажилгүйдэл, уул уурхайн олборлолтын эсрэг хөдөлгөөн зэрэг эгзэгтэй асуудлаарх олон нийтийн эсэргүүцэл Монголд түгээмэл байдаг.

8. **Монгол Улс байгалийн арвин их баялагтай бөгөөд 1990-ээд оноос хойш эрчимтэй хөгжиж байна.** Монгол Улс дэлхийн хэмжээний ашигт малтмалын орд (жишээлбэл, коксжих нүүрс, зэс, алт), бэлчээрийн болон онгон дагшин байгальтай. Дэлхийн хоёр дахь том эдийн засагтай хил залгаа орших бөгөөд хүн ам нь өндөр боловсролтой. 1990-ээд оны эхэн үеэс ядуурлыг бууруулах, хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр томоохон амжилтыг үзүүлж ирсэн. Монгол Улс Дэлхийн Банкнаас гаргадаг Хүмүүн капиталын индекс (ХКИ)-ээр харьцангуй сайн байр суурь эзэлж байгаа бөгөөд 2020 онд 0.61 оноо авсан нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг болон бага дунд орлоготой улс орнуудын дунджаас дээгүүр байна. Гар утасны сүлжээ хүн амын 99 хувийг хамардаг бөгөөд үүнээс 70 хувь нь ухаалаг гар утастай байна. Банкны үйлчилгээний хүртээмжийн хувьд дэлхийд дээгүүрт ордог.

9. **Нэг хүнд ногдох нийт орлого өссөн хэдий ч ядуурлын түвшин дорвитой буурахгүйн дээр тэгш бүс байдал нэмэгдэж байгаа гэсэн ойлголт, төрийн үйлчилгээ муу байгаа зэрэг нь уул уурхайн салбараас олсон орлого хүмүүсийн амьжиргаанд нөлөө үзүүлж байгаа эсэх талаар олон нийтэд эргэлзээ төрүүлсээр байна.** Монгол Улсын газар нутаг байгалийн баялгаар арвин их, нэг хүнд ногдох ашигт малтмалын асар их баялагтай улс орнуудын нэгд тооцогдоно. Оюу Толгой (ОТ) (зэс, алт), Таван толгой (ТТ) (нүүрс) зэрэг ордууд нь бүрэн ашиглалтад орсноор дэлхийн хамгийн том уурхайнуудын нэг болно. Ашигт малтмалын ордуудын хайгуулд хөрөнгө оруулалт хийснээр дэлхийн хэмжээний уурхай бий болох боломжтой. Энэхүү ашигт малтмалын баялаг нь Монгол Улсын хөгжлийг хөдөлгөгч гол хүчин зүйл төдийгүй иргэдийн хүлээлтийг өндөрсгөсөн. Гэсэн хэдий ч уул уурхайн салбарт нийт ажиллах хүчний дөнгөж 4 орчим хувь ажиллаж, тус салбараас үүдэлтэй байгаль орчин, нийгмийн шинэ сорилтууд үүсэж байна. Монголчуудын дийлэнх улс орны эдийн засаг уул уурхайгаас хамааралтай байгаад шүүмжлэлтэй ханддаг бөгөөд ялангуяа уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулагчдын гүйцэтгэх үүрэгт эргэлздэг. Эрдэс баялгийн өмчлөл, менежментийн асуудал нь улс төрийн хүрээнд гол асуудлуудыг үүсгэдэг бөгөөд энэ нь эргээд хөрөнгө оруулагчид болон хөрөнгийн зах зээлд нөлөөлж, тодорхойгүй байдлын эх үүсвэр болдог.

10. **Далайд гарцгүй, БНХАУ ба ОХУ-ын хооронд орших Монгол Улс нь хоёр хөрштэй тогтоосон харилцаандаа өндөр ач холбогдол өгөхийн зэрэгцээ “гуравдагч хөрш” -ийн харилцаагаа бэхжүүлэхийг зорьж, бүс нутагтаа улс төр, эдийн засгийн интеграцчиллыг нэмэгдүүлэхийг эрмэлздэг.** БНХАУ нь Монгол Улсын хамгийн том гадаадын хөрөнгө оруулагч, худалдааны гол түнш нь бөгөөд Монгол Улсын улсын нийт экспортын 90 орчим хувь нь тус улсад ногдоно. Орос, Монголын харилцаа нь олон жилийн түүхтэй бөгөөд “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай” Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ” 2020 онд хүчин төгөлдөр болсон. Монгол-Орос-Хятад гурван улсын эдийн засгийн коридор байгуулах нь үр ашигтай бөгөөд ОХУ-аас БНХАУ руу хий дамжуулах хоолойг Монголын нутаг дэвсгэрээр дамжуулан барьснаар тус улсыг эрчим хүчээр хангах боломж бүрдэх юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улс “гуравдагч хөрш”-ийн бодлого сурталчлах ажлаа идэвхжүүлж, Япон, БНСУ, АНУ, Европын холбоо, Энэтхэг улстай харилцаагаа бэхжүүлэв. Япон бол Монгол Улсын хувьд хамгийн том хоёр талт хандивлагч улс юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн АНУ-д хийсэн айлчлалын үеэр Монгол Улс ба АНУ-ын харилцааг “стратегийн түншлэл” -ийн түвшинд ахиулсан. Бүс нутгийн түвшинд 1990-ээд оноос хойш Монгол Улс Зүүн өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (АСЕАН)-ийн Бүс нутгийн чуулга уулзалт, Ази-Европын уулзалт болон бусад бүс нутгийн болон бүс хоорондын форумд оролцдог. Мөн эдийн

засгийн харилцаагаа улам өргөжүүлж, төрөлжүүлэх зорилгоор Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа (АПЕК)-д элсэхийг эрмэлзэж байгаа.

11. **КОВИД-19 цар тахал нь Монгол Улсын нийгэм, улс төрийн байдалд аль хэдийн нөлөөлөл үзүүлсэн.** Эрх баригчид 2020 оны эхэн үеэс КОВИД-19 цар тахлын эсрэг идэвхтэй арга хэмжээ авсан. 2020 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд дотооддоо халдвар дамжсан тохиолдол илрээгүй байсан. Санал асуулгаас харахад эрх баригч МАН 2020 оны 6 дугаар сард болсон сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулсан нь Засгийн газраас КОВИД-19 цар тахлын эсрэг санаачилгатай ажилласантай холбоотой гэж зарим талаар тайлбарлаж болох юм.<sup>1</sup> 2020 оны 11 дүгээр сард дотоодод халдвар илэрсэн тохиолдол анх гарсны дараа Засгийн газраас хөл хорио тогтоож, хурдан хугацаанд хатуу арга хэмжээ авсан нь одоог хүртэл мөрдөгдөж байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн удаан хугацаагаар зогсооход, ялангуяа өвлийн улирал эхэлж байгаа тул ядуу, орлого багатай өрхүүдэд эмзэг тусч байна. Гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдсэн зэрэг нийгэмд үүсэж буй бусад асуудлууд нь хөл хорио тогтоох арга хэмжээтэй холбоотой байж болзошгүй тул анхаарал хандуулах нь чухал юм.<sup>2</sup>

12. **Улсын хэмжээнд Монгол Улсын ядуурлын түвшин 2016 онд 29.6 хувь байсан бол 2018 онд 28.4 хувь болж ялимгүй буурсан байна.** Ядуурал хөдөө орон нутагт 2016-2018 оны хооронд бага зэрэг буурсан боловч хотод буураагүй байна. Эдийн засгийн хөгжил хөдөө орон нутаг илүү хурдацтай бөгөөд ядуу хүмүүст илүү ээлтэй өрнөсөн тул хөдөө орон нутагт ядуурлын түвшин 4 пунктээр буюу 2016 онд 34.9 хувь байсан бол 2018 онд 30.8 хувь болж буурчээ. Харин хот суурин газарт эдийн засгийн өсөлт эсрэгээрээ хүртээмж багатай байсны зэрэгцээ ядуурал буураагүй байна. Хотод ядуурлын түвшин 2016 онд 27 хувь байсан бол 2018 онд өөрчлөгдөөгүй хэвээрээ байна. Ядуурал хот суурин газарт улам их төвлөрч байна. Үндэсний ядуурлын түвшнээс доогуур амьжиргаатай ядуу хүмүүсийн эзлэх хувь нэлээд их байгаа бол бага, дунд орлоготой орнуудын хувьд олон улсын ядуурлын түвшнээс буюу өдрийн 3.20 ам доллар (2011 PPP)-оос доогуур орлоготой амьдарч буй хүмүүсийн тоо 5 орчим хувь хэвээр байна.<sup>3</sup>

13. **Сүүлийн арван жилийн хугацаанд тэгш бус байдал өөрчлөгдсөнгүй.** 2011-2018 оны хооронд нийт хүн амын дунд нэг хүнд ногдох бодит хэрэглээ жилд дунджаар 0.67 хувиар өсч байсан бол амьжиргааны түвшний доод 40 хувьд хамаарах иргэдийн хувьд бодит хэрэглээ нь 1.0 хувиар өссөн байна. Эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй уялдан тэгш бус байдал өөрчлөгдөөгүй бол тус хугацаанд хэрэглээний Жини индекс 32-34 хооронд байв.

14. **КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямрал нь ядуурлыг бууруулах чиглэлээрх сүүлийн үеийн багахан ололт амжилтад сөргөөр нөлөөлөхөөр байна.** Монгол Улсын Үндэсний статистикийн хороо болон Дэлхийн Банкнаас энэ оны 5 дугаар сарын сүүлд утсаар хийсэн өрхөд

<sup>1</sup> Жишээлбэл, Сант Марал сангийн судалгааг үзнэ үү, 2020 оны 5-р сар. [https://830a862d-3fe6-40e6-b731-5a65590fd0cf.filesusr.com/ugd/915e91\\_6967750f46d24ae49e445089ead06009.pdf](https://830a862d-3fe6-40e6-b731-5a65590fd0cf.filesusr.com/ugd/915e91_6967750f46d24ae49e445089ead06009.pdf).

<sup>2</sup> Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 2244 гэмт хэрэгтнийг 2020 оны 1-р сараас 3-р сард шалгасан нь 2019 оны мөн үеэс 99.3% -иар өссөн бөгөөд гэмт хэрэг үйлдэгчдийн 97.4% -ийг эрэгтэйчүүд эзэлж байна гэж мэдээлэв. Хамгаалах байранд хүсэлт гаргасан хүмүүсийн тоо 76.6% -иар өссөн байна. Тайлан нь хөл хориог бууруулах эхний шатны арга хэмжээний дараа гарсан.

<sup>3</sup> Улс орнууд эдийн засгийн хувьд өсч хөгжихийн хэрээр Олон улсын ядуурлын шугам (IPL, 1.90 доллар / хоног, 2011PPP) дээр суурилсан туйлын ядуурлын түвшин аажмаар дунд орлоготой орнуудын ард иргэдийн амьдралд хамааралгүй болж байна. Хятад, Тайланд, Монгол, Малайз зэрэг улсууд олон улсын ядуурлын түвшингийн 1 хувиас хэтрэхгүй байна. Ихэнх орны хувьд үндэсний нэг хүнд ногдох хэрэглээ, орлогоос хамаарч ядуурлын шугам нэмэгдэж байна. Бага дунд орлоготой ангиллын (LMIC) ядуурлын шугам (3.2 \$/хоног 2011PPP) нь дунджаас доогуур орлоготой орнуудын үндэсний ядуурлын шугамын дундаж утгыг үндэслэн бага дунд орлоготой орнуудын дунд олон улсын ядуурлын жишиг тогтоодог.

суурилсан судалгаанаас харахад КОВИД-19 цар тахлын дэгдэлтийг зогсооход чиглэсэн арга хэмжээ нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон малчин өрхүүдэд ихээхэн нөлөөлж байна.<sup>4</sup> Гэр бүлийн бизнес эрхэлж буй өрхийн бараг 90 орчим хувьд 2020 оны 1 дүгээр сарын сүүлчээс хойш орлогын тасалдал үүсжээ. Цар тахлын үеэр малчид тасралтгүй ажиллах боломжтой байсан боловч тээвэр ложистикийн үйл ажиллагаа тасалдаж, ноолуурын үнэ унаснаас мал аж ахуйгаас олох орлого нь буурчээ. КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь тогтмол цалинтай ажил эрхлэлтэд бага нөлөөлсөн боловч гурван өрх тутмын нэгээс илүү нь цалингийн орлого нь тасалдсан гэж хариулжээ. Засгийн газрын зүгээс нийгмийн халамжийн хүрээнд нэмэлт тэтгэмж олгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр арга хэмжээ авч байгаа хэдий ч нийт өрхийн бараг дөрөвний нэг, харин ядуу өрхийн<sup>5</sup> талаас илүү хувь нь ирээдүйн хүнсний аюулгүй байдал, өрхийн санхүүгийн асуудалд санаа зовниж байгаагаа илэрхийлсэн байна.

15. **КОВИД-19 цар тахлаас улбаатай эдийн засгийн агшилт нь амьжиргааны бүхий л түвшин дэх иргэдэд нөлөөлж байна.** Ядуу иргэд үр чадвар бага шаардагдах үйлдвэрлэл, нийтийн аж ахуй, уул уурхай, хувийн үйлчилгээ зэрэг салбаруудад түлхүү ажилладаг боловч эдгээр салбарууд нь цар тахалд илүүтэй өртөөд байна. Харин амьжиргааны дээгүүр түвшний иргэдийн ажлын байр харьцангуй баталгаатай, эсвэл гэрээсээ ажиллахад хүндрэлгүй байдаг. Ийм ч учраас амьжиргааны түвшний доод 20 хувьд хамаарах иргэд 2020 оны 1 дүгээр сараас 5 дугаар сарын хооронд ажилгүй байх магадлал өндөр байв. Хэдийгээр чинээлэг иргэд ажлын байраа алдах эрсдэл бага байж болох ч нийгмийн амьжиргааны бүхий л түвшинд буюу баян, ядуу ялгаагүй орлого нь буурсан байв. Гадаад, дотоод эрэлт буурч, аж ахуйн нэгжүүд хаагдаж, ажлын цаг багассан нь цалин хөлс ба/эсвэл бизнесийн ашиг орлого буурахад хүргэсэн байна.

16. **Засгийн газраас хэрэгжүүлж буй КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг ДБГ зэрэг олон улсын түншүүд дэмжиж байна.** Монгол Улс хөгжлийн түншүүдээсээ 400 сая орчим ам.долларын дэмжлэг авахаар төлөвлөж байна. Дэлхийн Банкнаас одоогоор яаралтай тусламжийн хүрээнд 62.85 сая ам.долларыг олгоод байна. Үүнд: “Дэлхий нийтийн КОВИД-19 цар тахалтай тэмцэх олон шатлал бүхий хөтөлбөр (МРА)”-ийн эхний багц болох эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний яаралтай тусламжийн төсөл (26.9 сая ам.доллар) болон боловсрол, нийгмийн хамгаалал, засаглал, ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүдээс дахин хуваарилагдсан хөрөнгө багтаж байна. ОУСК-аас КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээ болгож бизнес эрхлэгчид болон бичил зээлдүүлэгчдэд мөн санхүүжилт олгосон.

17. **ДБГ-ын 2017 онд хийсэн Монгол Улсын цогц дүн шинжилгээ/оношилгоо (ЦДШ) нь үндсэн гурван асуудлыг тодорхойлсон. Үүнд эдийн засгийн тогтворгүй өсөлт, хүн амын сайн сайхан амьжиргаанд учрах эрсдэл, хүрээлэн буй орчны стресс зэрэг хөгжлийн асуудлууд бөгөөд эдгээр сорилтуудын заримыг КОВИД-19 цар тахлын хямрал улам бүр хурцатгаж байна.**<sup>6</sup> Эдийн засгийн өсөлт ба уналтын мөчлөгүүд дахин дахин давтагдаж буй нь амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээрх өмнөх онуудын амжилтыг эрсдэлд оруулж байна. Хүн амын дундаж наслалт харьцуулж буй орнуудын түвшнээс харьцангуй бага байгаа, халдварт бус өвчний тохиолдол

<sup>4</sup> Судалгааны үр дүнг эндээс авна уу: <https://www.worldbank.org/en/country/mongolia/brief/monitoring-covid-19-impacts-on-households-in-mongolia> [шинэ судалгаагаар цаашид шинэчлэгдэх болно]

<sup>5</sup> Ядуурлын дүр төрхийг 2018 оны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд үндэслэв

<sup>6</sup> Дэлхийн Банк, Монгол Улс: Цогц дүн шинжилгээ.2018.

<https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/30973/mongolia-scd-final-version-november-2018-11282018-636792121231072289.pdf?sequence=1&isAllowed=y>. ЦДШ-г 2018 онд анх төлөвлөсөн ТС боловсруулахад зориулан бэлтгэсэн. Дараа нь ТС-ийг хойшлуулаад ГСД-ийг 2019 онд боловсруулсан болно. Гэсэн хэдий ч ЦДШ-ний шинжилгээ хүчин төгөлдөр хэвээр байгаа бөгөөд ДБГ-ны бусад шинжилгээний ажилтай үялдуулсан болно.

нэмэгдэж байгаа нь хүн амын сайн сайхан байдалд ноцтой эрсдэл учруулж байна. Хүн амын бараг тэн хагас нь гэр хороололд амьдарч, орон сууц хангалтгүй бөгөөд ариун цэврийн байгууламж, төвлөрсөн дулаан хангамж, зам тээврийн хүртээмж хязгаарлагдмал байгаа нь хүн амын эмзэг байдлыг зарим талаар харуулж байна. Уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагаанаас үүдэн гамшгийн эрсдэл нэмэгдэж, байгаль орчны доройтол их байна.

18. **ЦДШ нь Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх үндсэн хоёр стратеги болох биет бус капитал бий болгох, бодит хуримтлал үүсгэхийг санал болгосон.**<sup>7</sup> “Биет бус капитал” бүрдүүлэх гэдэг нь Засгийн газрын төлөвлөлт, үйл ажиллагааг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах үр ашигтай зохицуулалт, чадварлаг байгууллагын тогтолцоог бий болгохыг хэлнэ. Энэхүү биет бус капитал нь нөөцийн тогтворгүй орлогыг илүү сайн удирдах, бизнесийн өрсөлдөөнийг дэмжих, нийгмийн үйлчилгээний чанарыг сайжруулах болон байгалийн баялгийг хамгаалахад шаардлагатай юм. Тухайн асуудлыг зохицуулж буй Монгол Улсын хууль тогтоомжууд хатуу чанд, орчин үеийн шинжтэй байгаа боловч эдгээр хуулиудын хэрэгжилт сул байдаг тул цаашид хэрэгжилтийг хангаж ажиллах, хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Нөгөө талаас, Монгол Улс санхүүгийн, биет болон хүмүүн капиталын илүү олон төрөлжсөн багцыг хуримтлуулах шаардлагатай байна. Эдгээр “бодит хуримтлал” нь түүхий эдийн экспортоос эдийн засгийн харьцангуй үр өгөөж бүхий капиталын шинэ хэлбэрт шилжихэд чиглэгдэж, улс орны өрсөлдөх чадвар байгалийн нөөцөөс хүмүүн болон бусад капиталын хэлбэрт шилжихийн хэрээр эдийн засгийн төрөлжилт байгалийн жамаар хөгжих юм. Үүний үр дүнд Монгол Улс гадаад цочролд өртөх магадлал буурна. Монгол Улсын хийсэн хөрөнгө оруулалтын мэдээллээс харахад сүүлийн жилүүдэд уул уурхайд оруулах хөрөнгө оруулалт маш их байсан бол дэд бүтэц, хүмүүн капитал, байгалийн нөөцийг хадгалах чиглэлээрх хөрөнгө оруулалт харьцангуй бага байна.

19. **Хоёр бүлэг гол сорилтод үндэслэн ЦДШ нь Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх таван зорилтын жагсаалтыг санал болгосон.**

- **Засаглал бол бүхий л чухал тулгамдсан сорилтуудын суурь асуудал юм.** Эдийн засгийн засаглалын гол сорилт нь макро эдийн засгийн оновчтой удирдлага юм. Дээр нь нэмээд засаглалын гурван ерөнхий асуудлыг дурдаж болно. Үүнд: сонгуулийн мөчлөг дагасан бодлого (өсөлт-уналт-тусламж эрэх гэсэн мөчлөгийг улам бүр даамжруулдаг), хууль тогтоомжийг дагаж мөрдөх, түүнийг хэрэгжүүлэх явдал хангалтгүй (“хэрэгжилтийн хоцрогдол” үүсдэг), улс төрчдийн клиентилистик (танил тал, тохой татсан) улс төрийн өрсөлдөөн, парламентын бүрэлдэхүүнд өөрчлөлт орох бүрт гарах өөрчлөлтүүд, тэр дундаа төрийн албан хаагчдын ойр давтамжтай халаа сэлгээ зэрэг багтана.

- **Ажлын байр ба хувийн хэвшлийн хөгжил бол** ихэнх монголчуудын өмнө тулгамдсан суурь асуудал юм. Ажилгүйдэл, ялангуяа залуучуудын ажилгүйдлийн түвшин өндөр, мөн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо бага байгаа нь ажлын байр нэмэгдүүлэхийн төлөө илүү сайн чармайх шаардлагатайг харуулж байна. Эдийн засаг өсөж байгаа ч сүүлийн үеийн төгсөгчдийн үр чадвар (ялангуяа дээд боловсролын түвшинд) ажлын байрны шаардлага хангахгүй байгаагийн улмаас ажил эрхлэлт, бүтээмж, илүү өндөр үнэ цэнэ бүхий ажлын байрны өсөлт зогсонги байдалд ороход нөлөөлж буй гол шалтгаан болж байна. Эдийн

---

<sup>7</sup> Эдгээрийн заримыг ДБГ-ын олон талт хөгжлийн тайлангаас авсан бөгөөд үүнд байгалийн баялаг ихтэй хэд хэдэн орны хөгжлийн туршлагыг судалсан болно. Gill, Indermit et al, Diversified Development. Евразийн байгалийн нөөцийг хамгийн их ашиглах нь, ДБГ, Вашингтон, 2014 он.

засгийн өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлэх гол хөшүүрэг болох хувийн хэвшлийн хөгжил нь төсвийн бодлогын нөлөө, урьдчилан таамаглах боломжгүй хөрөнгө оруулалтын орчноор хязгаарлагдаж байна. Монгол улсын бизнес эрхлэх үзүүлэлтэд ахиц гарч байгаа хэдий ч хувийн хөрөнгө оруулагчид Монгол улсыг өндөр эрсдэлтэй орчин гэж дүгнэсээр байна.

• **Хүмүүн капиталыг хуримтлуулах ба хамгаалах: эрдэс баялгийг хүн амын аж байдлыг сайжруулахад чиглүүлэх.** Эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд нь эмнэлгийн анхан шатны түслэмж үйлчилгээг өргөжүүлэх, чанарыг сайжруулахын зэрэгцээ халдварт бус өвчинтэй тэмцэхийн тулд эмнэлгийн тогтолцоон дахь урамшууллыг илүү оновчтой болгохыг шаардаж байна. Боловсролын салбар дахь төсвийн зарцуулалт дунд түвшинд (ижил түвшний улс орнуудтай харьцуулахад) байгаа боловч хүн ам бүтцийн хувьд залуу, мөн хотжилт хурдацтай явагдаж байгаагаас шалтгаалан ялангуяа сургуулийн өмнөх боловсролын эрэлт, нийлүүлэлтийн зөрүү улам бүр ихэссээр байна. Үүнээс гадна илүү өндөр үнэлэмж бүхий ажлын байранд ирээдүйд ажиллах хүчийг бэлтгэхийн тулд дээд боловсрол, мэргэжлийн боловсролын чанарыг дээшлүүлэх шаардлагатай юм. Түүнчлэн, нийгмийн хамгааллын тогтолцоог илүү зорилтот болгож, төсөв санхүүгийн хувьд сайжруулах шаардлагатай байна. Нийгмийн хамгааллын тогтолцоо нь хамрах хүрээ, тэгш байдлын хувьд хүлээн зөвшөөрөгдөхүйц боловч макро цочрол болон ядуурлыг бууруулахад үзүүлэх үр нөлөө нь хязгаарлагдмал байсаар байна. Тэтгэврийн тогтолцоонд үзүүлж буй төсвийн татаас улам бүр нэмэгдсээр байгаа тул тэтгэврийн тогтолцоонд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

• **Дэд бүтэц: ирээдүйн эдийн засгийн төрөлжилтийн үндэс суурь. Том хэмжээний** газар нутагтай, далайд гарцгүй Монгол Улсын хувьд тээвэр, ложистик бол тулгамдсан, чухал асуудал мөн. Төр нь эрчим хүч, ус, тээвэр зэрэг үндсэн дэд бүтцэд ихээхэн оролцоотой бөгөөд эдгээр салбарт чухал тоглогч хэвээр байх төлөвтэй. Гэсэн хэдий ч хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн хувилбарууд нь төсвийн дарамтыг бууруулж, өсөн нэмэгдэж буй улсын өрийг дарахад дэм болохоос гадна эцсийн хэрэглэгчдэд илүү сайн технологи, засаглал болон үр ашигтай нийтийн үйлчилгээ хүргэх боломжийг бүрдүүлнэ.

- **Байгалийн нөөцийг хамгаалах: хэт ойрыг харсан бодлого маш том алдааны эх болно.** Уур амьсгалын өөрчлөлт, сүүлийн үеийн эдийн засгийн нөхцөл байдал нь байгалийн баялгийн доройтолд нөлөөлж байна. Зарим бүс нутагт усны эх үүсвэр шавхагдаж, Улаанбаатар хотын агаарын бохирдол өндөр түвшинд хүрч, бэлчээрийн доройтол, гамшгийн эрсдэл нэмэгдэж байгаа зэрэг нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дэд бүтцийг сайжруулахад нэмэлт хөрөнгө оруулалт хийхийг шаардаж байна. Байгалийн баялгийг ашиглахтай холбоотой ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг ил тод хэлэлцэх,үүнтэй холбоотой алдаа, оноог ойлголцох шаардлагатай.

20. **Дэлхийн Банк Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа (ЭЗХЗТС)-г саяхан боловсруулж, нийтэлсэн бөгөөд энэхүү тойм нь ЦДШ-тэй уялдуулан Монгол Улсын хөгжлийг түргэтгэх зорилгоор "Уул уурхайгаас оюун ухаан руу" шилжих шилжилтийг дэмжсэн**

юм.<sup>8</sup> Уг тайланд төрөлжсөн, тогтвортой өсөлтийг дэмжсэн эдийн засгийн суурийг бий болгох бодлогын үндсэн дөрвөн багц арга хэмжээг сөн. Үүнд:

- Бизнесийн мөчлөгөөс үл хамааран ийн дагуу хэрэглээг тогтворжуулахын тулд мөчлөг сөрсөн төсвийн болон мөнгөний бодлого хэрэгжүүлэх;
- Өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрхийг баталгаажуулах, илүү тэгш өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын орчны шинэчлэл хийх;
- Бүтээгдэхүүнээ төрөлжүүлэх сэтгэлгээнээсээ салж, оюуны чадавх руу шилжих, ялангуяа Монгол Улсын залуу, боловсролтой, эмэгтэй ажиллах хүчнийг илүү сайн ашиглах;
- Улс төрийн хөндлөнгийн оролцоог бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, зохицуулалтын чанарыг сайжруулах зорилгоор засаглалын суурь шинэчлэлийг хурдасгах.

21. **Монгол Улсын хувьд эрүүл мэнд, боловсролын салбарт жендерийн ялгааг арилгах чиглэлээр ахиц гарсан ч, дундаж наслалт, эдийн засгийн боломж, хөрөнгийн өмчлөл болон эрх мэдэл, дүү хоолойгоо хүргэхтэй холбогдсон чухал асуудлуудад дорвитой ахиц гараагүй хэвээр байна.**<sup>9</sup> Эмэгтэй ажиллах хүчний оролцооны түвшин 53%, харин эрэгтэйчүүдийн оролцооны түвшин 68% (2019)-тай байна. Хүйсийн ялгаа 2016 онд 12 нэгж байсан бол 2019 онд 15 нэгж болж өсөв. Дунджаар эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага цалин авдаг; хүйсийн цалингийн ялгаа 25%-д хүрсэн.<sup>10</sup> Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) нь нийгмийн өргөн хүрээтэй асуудал хэвээр байгааг эмэгтэйчүүдийн 31% нь амьдралынхаа туршид бие мах бодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан бол байнгын хамтрагчтай эмэгтэйчүүдийн 58% нь хамгийн багадаа нэг төрлийн хүчирхийлэлд өртөж байсан харуулж байна.<sup>11</sup> КОВИД-19 цар тахлаас үүдэн гэр бүлийн хүчирхийлэл улам даамжирч байна. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 9.67 жилээр урт насалдаг бөгөөд дундаж наслалтын хүйсийн зөрүүтэй байдал улам бүр нэмэгдэж байна. Насанд хүрсэн эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдтэй харьцуулахад бараг 2.4 дахин их байна.

22. **КОВИД-19 цар тахал нь ЦДШ ба ЭЗХТ-д тодорхойлсон зарим үндсэн бэрхшээлийг улам даамжруулсан.** КОВИД-19 цар тахал нь макро эдийн засгийн болон төсвийн удирдлагын хувьд маш ихээр нөлөөлж байна. Макро эдийн засаг, мөнгөний бодлогыг сайжруулах, төсвийн сахилга батыг бэхжүүлэх асуудал нь илүү төвөгтэй болж байна. КОВИД-19 цар тахал нь хүний эрүүл мэнд болон боловсролд нөлөөлөх замаар хүмүүн капиталд өмнө бий болсон ахиц дэвшлийг сулруулж байна. Түүнчлэн, ядуу иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг улам сайжруулах шаардлага бий болж байна. Нийгмийн хамгааллын тогтвортой, илүү зорилтот бүлгүүдэд чиглэсэн бодлого урьд урьдынхаас илүү чухал болж байна. КОВИД-19 цар тахлын хөл хорионы үеэр жендерийн шинжтэй хүчирхийлэл нэмэгдсэн нь жендерийн тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийллийг шийдвэрлэх шаардлага байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ, КОВИД-19 цар

<sup>8</sup> Нгану, Жийн-Паскаль; Эккардт, Себастиан; Жао, Луан; Батсуурь, Даваадалай; Батмөнх, Ундрал; Д'Хульстер, Катиа 2020. Уул уурхай ба оюун ухаан: Хүмүүс, байгууллагуудад хөрөнгө оруулах байгалийн баялгийг ашиглах (Англи хэл дээр). Вашингтон, ДС.: Дэлхийн Банк Грүпп.<http://documents.worldbank.org/curated/en/273001600370275964/Mines-and-Minds-Leveraging-Natural-Wealth-to-Invest-in-People-and-Institutions>

<sup>9</sup> Жендерийн талаарх дараах гол үнэлгээнүүдээр ТСХ-д мэдээлэв: i) Дэлхийн Банк (2018) Эрсдэлтэй байдлын талаарх ойлголт: Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн ялгаатай байдлын чанарын судалгаа; ii) УСХ ба АХБ, Монгол дахь хөрөнгийн өмчлөл ба бизнес эрхлэлтийг жендерийн талаас нь хэмжих туршилтын судалгаа, 2018. Мөн; iii) IRIM (Монголын Хараат Судалгааны Хүрээлэн) ба НҮБХХ (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр) (2016) ТХЗ-уудад чиглэсэн урсгал, хурдатгал ба бодлогын дэмжлэг (MAPS): Монгол дахь ТХЗ-уудын эсрэг хүйсийн суурь шинжилгээ.

<sup>10</sup> Үндэсний Статистикийн Хорооны мэдээлэл, 2020 оны 4-р сар.

<sup>11</sup> НҮБ-ын Хүн амын сангаас авсан мэдээлэл (НҮБ-ын Хүн амын сан), 2018 он.

тахлын үед харилцаа холбоог сайжруулж, мэдээлэл харилцаа, холбооны технологийн дэд бүтцийг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

### III. ДЭЛХИЙН БАНК ГРУППЫН ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИ

#### Зураг 1: ТСХ-ний чиглэл ба зорилтууд

Ерөнхий зорилго: уян хатан сэргэлт, хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжих

<b>Чиглэл 1:</b> <b>Эдийн засгийн сэргэлт, тогтвортой байдлыг дэмжих</b> <small>- ТХЗ 8: Зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлт - ТХЗ 10: Тэгш бус байдлыг бууруулах - ТХЗ 16: Энх тайван, шударга ёс ба хүчирхэг байгууллагууд</small>	<b>Чиглэл 2:</b> <b>Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, чанартай ажлын байр бий болгох</b> <small>ТХЗ 1: Ядууралгүй байх - ТХЗ 4: Чанартай боловсрол - ТХЗ 5: Жендэрийн тэгш байдал - ТХЗ 7: Боломжийн ба цэвэр эрчим хүч - ТХЗ 8: Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлт - ТХЗ 9: Аж үйлдвэр, инноваци ба дэд бүтэц - ТХЗ 10: Тэгш бус байдал буурсан - ТХЗ 11: Тогтвортой хотууд ба олон нийт - ТХЗ 16: Энх тайван, шударга ёс ба хүчирхэг байгууллагууд</small>	<b>Чиглэл 3:</b> <b>Хүмүүн капиталыг өргөжүүлэх ба амьдралын чанарыг дээшлүүлэх</b> <small>ТХЗ 1: Ядууралгүй байх - ТХЗ 2: Тэг өлсгөлөн - ТХЗ 3: Эрүүл мэнд, сайн сайхан байдал - ТХЗ 4: Чанартай боловсрол - ТХЗ 5: Жендэрийн тэгш байдал - ТХЗ 8: Зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлт - ТХЗ 9: Аж үйлдвэр, инноваци ба дэд бүтэц - ТХЗ 10: Тэгш бус байдлыг бууруулсан</small>
<p>1.1 КОВИД-19 цар тахлын нөлөөллийг арилгахын тулд эдийн засгийн яаралтай тусламж үзүүлэх</p> <p>1.2 Макро- төсвийн удирдлага, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх</p>	<p>2.1 Бизнесийн орчныг сайжруулах</p> <p>2.2 Тогтвортой уул уурхай, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих</p> <p>2.3 Уул уурхайн бус салбар дахь бүтээмж, хотын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх</p>	<p>3.1 Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (үүнд КОВИД-19 цар тахлын эрүүл мэндийн хариу арга хэмжээг багтаасан)</p> <p>3.2 Нийгмийн хамгааллын тогтолцооны үр ашиг, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх</p> <p>3.3 Амьжиргааг сайжруулах, хүрээлэн буй орчин, уур амьсгалыг хамгаалах</p>

Холбогдох бусад сэдэв:

Засаглал: төрийн байгууллагуудыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах

Уян хатан байдал: эдийн засаг, хүн ба хүрээлэн буй орчны уян хатан чанарыг дээшлүүлж, сайн сайхан байдлыг бий болгох

23. **ДБГ нь энэхүү ТСХ-нд тулгуурлан Монгол дахь хамтын ажиллагааны тасралтгүй байдлыг хангахын зэрэгцээ илүү сонгомол, зорилтот, шинэ зээлийн үйл ажиллагаагаар дамжуулан эдийн засгийн бодит үр өгөөж бүхий салбаруудад төвлөрөх зорилготой болно.** (1) Олон салбарыг хамарсан жижиг төслүүдээс цөөн тооны, эдийн засгийн үр өгөөж бүхий бодит салбаруудад чиглэсэн томоохон хөрөнгө оруулалтын зээлд түлхүү анхаарах. Банкнаас хэрэгжүүлж буй 13 төслийн багц нь нийт 9 салбарыг хамарч байгаа бөгөөд төсөл тус бүр дунджаар 26.8 сая ам.долларын санхүүжилттэй байна. Түүнчлэн, засаглал, байгууллагын бүтэц зохион байгуулалтын асуудлыг дэмжих зорилгоор техник туслалцааны хэд хэдэн төслийг хэрэгжүүлж байна. Шинэ ТСХ-ний дагуу Банкны зээлийн шинэ гэрээ хэлэлцээрүүд нь эдийн засгийн бодит салбарт шилжиж, илүү зорилтот, боломжит цөөн тооны боловч томоохон үйл ажиллагаанд чиглэгдэнэ. Чанартай ажлын байр бий болгох чиглэл нь дээрх

зорилтыг тодорхойлох чухал хүчин зүйл юм. Монгол Улсын хувьд зөвхөн Олон Улсын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ОУСБХБ)-ны үйлчлүүлэгч болсноор энэхүү шилжилтийн үр дүнд гадаадаас авах зээлийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх чухал ач холбогдолтой. (2) Хөгжлийн бодлогын үйл ажиллагаа (ХБҮА), өндөр чанарын зөвлөх үйлчилгээ, дүн шинжилгээ (ЗҮДШ) болон бусад зээлийн бус хэрэгслүүдийг ашиглан бодлогын шинэчлэлийг дэмжинэ. ХБҮА нь бодлогын шинэчлэлийн талаарх хэлэлцээ, техникийн зөвлөмжид тулгуурлан бодлогын шинэчлэлийг урагшлуулах чухал хэрэгсэл болно. Нийгмийн хамгаалал, ус, эрчим хүч зэрэг салбарт чанарын өндөр түвшинд дүн шинжилгээ хийдэг нь Банкны харьцангуй давуу тал бөгөөд ДБГ-ыг Монгол Улсын нэр хүндтэй түнш хэвээр үлдэхэд дэм болдог. (3) Нэмж дурдахад, ДБГ-ын бүхий л үйл ажиллагаа нь КОВИД-19 цар тахлын нөлөөг сааруулах,, "илүү эрчимтэй сэргэлтийг" дэмжих зэрэгт чиглэнэ.

24. **Энэхүү ТСХ-ний хөтөлбөр нь ЦДШ-тэй нягт уялдсан болно.** ЦДШ-ийн засаглал, хувийн хэвшлийн хөгжил, хүний хөгжил, дэд бүтэц, байгалийн баялгийг хамгаалах тэргүүлэх чиглэлүүд нь ТС-д тусгайлсан чиглэл эсвэл нэг ба түүнээс дээш зорилтод тусгалаа олсон байгаа. ЦДШ-д тодорхойлсон тэргүүлэх ач холбогдол бүхий үйл ажиллагааны ихэнх нь ТСХ-ний хөтөлбөрт тусгагдсан байгаа. Гэсэн хэдий ч ЦДШ-т онцлон тусгагдсан сорилтуудын бүх талыг энэхүү ТС-ийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй юм. ДБГ-ын оролцоог тодорхойлохдоо Засгийн газрын санхүүжилтийн төлөвлөгөө, тэргүүлэх чиглэл, хөгжлийн бусад түншүүдийн оролцоо, ДБГ-ын боломжит санхүүжилт, үйлчлүүлэгчидтэй хийх яриа хэлэлцээ зэргийг бүгдийг харгалзан үзсэн болно. Жишээлбэл, Монгол Улсын эрүүл мэндийн салбарт Азийн Хөгжлийн Банк (АХБ) чухал үүрэг гүйцэтгэдэг тул КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээг дэмжихээс өөр арга хэмжээг Банк санхүүжүүлэхээр төлөвлөөгүй болно. Үүний зэрэгцээ хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд хэд хэдэн түншлэгч ус хангамж, цэвэршүүлэх чиглэлд үйл ажиллагаа хэрэгжүүлдэг тул Банкнаас байгалийн нөөцийн менежментэд зориулан тусгай санхүүжилт төлөвлөөгүй болно. Дэд бүтцийн салбарт, ялангуяа санхүүжилтийн хэрэгцээ тун их байгаа тул хувийн хэвшлийн шийдлүүдийг дайчлах, бусад хөгжлийн түншүүдтэй хамтран ажиллах, зохицуулах нь чухал үүрэг гүйцэтгэнэ.

25. **Монгол Улсын эдийн засаг, улс төрийн байдал тогтворгүй, мөн КОВИД-19 цар тахлын хямрал үргэлжилж буйн улмаас ДБГ-ын оролцоо уян хатан хэвээр байх болно.** Өнгөрсөн түршлагаас харахад, байгалийн баялаг ихтэй, үнийн цочролд өртөмтгий улс орнууд эсвэл Засгийн газар нь байнга солигддог улс орнуудад дэмжлэг үзүүлэх гол түлхүүр нь хамтын ажиллагааны уян хатан байдал юм.<sup>12</sup> Хувьсан өөрчлөгдөж буй КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал эргэлзээ төрүүлсээр байна. Хэрэв тухайн улс орны нөхцөл байдал өөрчлөгдвөл эсвэл өөрчлөлт хийх шинэ боломжууд гарч ирвэл ДБГ нь ТСХ-нд тусгагдаагүй ажлыг хэрэгжүүлэхээр шийдэж болно. Ийм зохицуулалтыг Гүйцэтгэл ба Сургамжийн дүгнэлт (ГСД)-д тусгах болно.

### **3.3 Чиглэл тус бүрт ДБГ-ээс үзүүлэх дэмжлэгийн зорилго**

#### **Чиглэл 1: Эдийн засгийн сэргэлт, тогтвортой байдлыг дэмжих**

##### **Зорилго 1.1 КОВИД-19 цар тахлын эдийн засгийн үр нөлөөг арилгахад яаралтай тусламж үзүүлэх**

26. **КОВИД-19 цар тахлын Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь маш их бөгөөд хувьсан өөрчлөгдөж байна.** Цар тахлын эдийн засгийн өсөлт, хүн амд үзүүлж буй

<sup>12</sup> Хараат бус үнэлгээний групп 2015, Байгалийн баялгаар баялаг хөгжиж буй орнуудын ДБГ-ын оролцоо: Боливи, Казахстан, Монгол, Замби зэрэг олон улсын муж улсын тохиолдлуудыг үзнэ үү. Улс орны хөтөлбөрийн үнэлгээний нэгтгэсэн тайлан, Дэлхийн Банк, Вашингтон, ДС.

нөлөөллийн талаар дээр дурдсан болно. Гэсэн хэдий ч хямрал дуусаагүй байна. Саяхан дотоодод КОВИД-19 цар тахлын халдвар тархсан нь нийгмийн эрүүл мэндийн хямралын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Үүний улмаас түр хугацаагаар хөл хорионы арга хэмжээг чангатгах, төсвийн зарим арга хэмжээг 2021 оны 6 дугаар сарыг дуустал сунгахад хүргэж, улмаар макро эдийн засгийн төлөв байдлыг улам дордуулж болзошгүй юм. Хэрэв дотооддоо халдварын тархалтыг хяналтдаа авч чадахгүйд хүрэх эсвэл хөл хорионы арга хэмжээ улам сунжирвал эдийн засгийг дэмжих шаардлага илүү их нэмэгдэх болно.

**27. Одоогийн байдлаар аваад буй онцгой байдлын хариу арга хэмжээнд үндэслэн ДБГ нь цар тахлын улмаас цаашид шаардлагатай тохиолдолд яаралтай тусламж үзүүлэх нэмэлт нөөцийг дайчлахад бэлэн байх болно.** Одоогийн байдлаар ДБГ-ын яаралтай тусламжийн санхүүжилтийн дийлэнх хэсгийг нийгмийн даатгалын сангаар дамжуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ, нийгмийн хамгаалалд чиглүүлж, ОУСК-аас хувийн хэвшилд санхүүжилт олгоод байна. Нийгмийн эрүүл мэндийн дэмжлэг нь КОВИД-19 цар тахлыг хянах, урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээг хөнгөвчилсөн бөгөөд вакцины санхүүжилт нь тахал өвчнийг даван туулж, улмаар эдийн засаг, нийгмийн хэвийн үйл ажиллагаанд шилжихэд дэм болох юм. Нийгмийн даатгалын санд оруулсан дэмжлэг нь ажилчид болон компаниудад санхүүгийн түргэн шуурхай тусламж болж чадсан.<sup>13</sup> Компани, аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэл, ажлын байраа хадгалах боломж, жижиг аж ахуйн нэгжүүдэд олгох санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дэмжих зорилгоор ОУСК-ийн санхүүжилтийг олгосон. Цаашид эдийн засгийн хэрэгцээ шаардлагаас хамаарч ДБГ нь өөрийн бүхий л хэрэгслээр дамжуулан дэмжиж ажиллах бөгөөд эдгээр хэрэгслүүдэд хөгжлийн бодлогын зээл мөн багтана.

## **Зорилго 1.2 Макро- төсвийн удирдлага, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх**

**28. Монгол Улсын хөгжилд нөлөөлж буй эдийн засгийн тогтворгүй байдлыг сааруулах нь зүйтэй.** Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн тогтворгүй байдал, өндөр хэлбэлзэл нь түүхий эдийн үнийн хэлбэлзлээр илэрхийлэгдэнэ. Баялгийн хараалын нөлөөллийг бууруулахын тулд макро эдийн засгийн оновчтой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Төсвийн бодлогын хувьд төсвийн дүрмийг хялбарчилж, өрийг бууруулах, болон Төсвийн тогтворжуулалтын сан (ТТС)-гийн үйл ажиллагааг жигдрүүлэх ажлыг нэгдүгээрт тавих, мөн өрийн менежментийг бэхжүүлэх шаардлагатай байна. Мөнгөний бодлогын хувьд гадаад валютын (ГВ) интервенцийг хязгаарлаж, нэрлэсэн ханшийн уян хатан байдлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн мөчлөг сөрсөн оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Гаалийн шинэчлэл нь гаалийн үйл ажиллагааг хялбарчилж, байгалийн баялгаас бусад бүтээгдэхүүний гадаад худалдааг дэмжихэд чухал ач холбогдолтой юм.<sup>14</sup>

**29. ДБГ нь Монгол Улсад зээл олгох, судалгаа шинжилгээ хийх замаар Монгол Улсын эдийн засгийн менежментийг сайжруулахад үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх болно.** Саяхан нийтлэгдсэн ЭЗХТ нь эдийн засгийг тогтворжуулах чиглэлээр Банкны зүгээс үзүүлэх сүүр үйлчилгээ буюу эдийн засгийн нөхцөл байдалд хийсэн судалгаа шинжилгээний ажил юм. Макро-төсвийн уян хатан байдлыг бэхжүүлэх, түүнчлэн бусад чухал салбаруудад шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эдийн засгийн менежментийг дэмжих сүүлийн үйл ажиллагаа (ЭЗМДҮА)-нд үндэслэн шинэ

<sup>13</sup> Банкны дэмжлэг нь 72,000 эмэгтэй, түүний дотор албан бус хувиараа хөдөлмөр эрхэлдэг 120,000 гаруй албан хаагч, мөн КОВИД-19 цар тахлын нөлөөлөлд өртсөн 18,000 пүүсийн 150,000 орчим ажилчинд нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлж байна. Банкны дэмжлэгээр ашиг хүртэгч компаниуд төлбөрийн чадвараа хадгалах, ажлын байраа хадгалахад нь туслах нэмэлт мөнгөн гүйлгээтэй болно. Ашиг хүртэгчид КОВИД-19-ийн хямралыг даван туулахын тулд нэмэлт бэлэн мөнгөтэй байхын зэрэгцээ ажлын байраа хадгалж, нийгмийн даатгалын тэтгэмж авах боломжтой болно.

<sup>14</sup> Тэмдэглэл 10-ыг үзнэ үү.

хөгжлийн бодлогын үйл ажиллагааны хөтөлбөр (ХБҮАХ)-ийг боловсруулж болох юм. Банкны зүгээс бодлогын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа өмнөхийн адил ОУВС болон бусад түнш байгууллагуудтай нягт уялдаатай ажиллана. Одоо хэрэгжиж буй Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд төсвийн сахилга батыг бэхжүүлэх, төрийн санхүүгийн удирдлагын чанарыг сайжруулах, эдийн засгийн бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх зэрэг олон чиглэлд шинэчлэл хийхээр техникийн туслалцаа үзүүлж байна. Судалгаа, дүн шинжилгээ хийх бусад үйл ажиллагаанд салбарын Төсвийн зарлагын тойм (ТЗТ) болон Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ)-уудын санхүүгийн эрсдэлийн үнэлгээ багтана. Эцэст нь хэлэхэд, Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-той хамтран хийх ЗҮДШ нь олон хэмжээст ядуурлыг бууруулах арга хэмжээг нэвтрүүлэх ажлын хүрээнд нийгэм, эдийн засгийн гол мэдээллийн чанарыг сайжруулж цаг хугацааны хувьд хоцрогдолгүй байлгахад сайжруулахад туслах болно.

**30. Санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн үр ашгийг сайжруулах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд гаргасан хүчин чармайлтаас гадна банк давамгайлсан санхүүгийн салбар бэрхшээлтэй тулгарсан хэвээр байна.** Макро эдийн засгийн болзошгүй эрсдэлийг үүсгэх нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь банкны салбар бөгөөд шинэчлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт дутуу хэвээр байна. Монгол Улс FATF-ийн саарал жагсаалтаас гараад д удаагүй байгаа хэдий ч мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) асуудлаар цаашид ажиллах шаардлагатай байна. Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорац (ХДК)-ын зүгээс санхүүгийн салбарын тогтвортой, аюулгүй байдлыг хангах үүргээ гүйцэтгэхэд хөрөнгө дутагдаж байгаагийн зэрэгцээ үйл ажиллагааг нь цаашид бэхжүүлэх шаардлагатай байна. Төлбөр тооцооны инноваци, дэвшлийг дэмжих замаар санхүүгийн салбарын дэд бүтцийн чухал элементүүдийг сайжруулах шаардлагатай байна. Түүнчлэн, ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр, хууль эрх зүйн орчныг шинэчлэх, Монгол Улсын Хөгжлийн банк (Монгол Улсын ХБ)-ны шинэчлэлийг дэмжих нь санхүүгийн салбарыг сайжруулах чухал элемент болно.

**31. Санхүүгийн салбарт гарсан ахиц дэвшлийг цаашид үргэлжүүлэхдээ Дэлхийн Банк нь илүү зорилтот оролцоогоор хангаж ажиллана.** Дэлхийн Банк нь тус улсын санхүүгийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр арваад жилийн турш ажиллаж, шинэчлэлийг дэмжихээс гадна хэд хэдэн гол хууль тогтоомжийг боловсруулж, хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан. Монгол Улс ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр болон Дэлхийн Банкны гурав дахь удаагийн Эдийн засгийн менежментийг дэмжих хөтөлбөр (ЭЗДХ)-т хамрагдсан боловч, 2019-2020 онд санхүүгийн салбарт ахиц гараагүй тул дээрх хөтөлбөрүүд дуусгавар болсон. Иймд санхүүгийн салбарын шинэчлэлийн арга хэмжээг шинэ ХБҮА-ны хүрээнд үргэлжлүүлэх болно. Банкнаас хэрэгжүүлж буй Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд банкны салбарын уян хатан байдлыг дэмжихэд зориулан техник туслалцааг үргэлжлүүлэн үзүүлнэ. Монгол Улсын санхүүгийн салбарын техник туслалцаа нь банкны салбарт зайлшгүй хийх хяналт шинжилгээний үйл ажиллагааг дэмжиж, холбогдох бодлогын зөвлөгөөг өгөхөд чиглэнэ. Эцэст нь, Дэлхийн Банкны хөрөнгийн удирдлагын нэгжээс Дэлхийн Банкны Нөөцийн асуудлаарх зөвлөх ба менежментийн хөтөлбөр (НЗМХ)-ийн хүрээнд Монголбанкны нөөцийн удирдлагыг сайжруулах чиглэлээр техник туслалцаа болон чадавхыг бэхжүүлэх үйлчилгээг үзүүлж байна. Мөн түүнчлэн Дэлхийн Банкны хөрөнгийн удирдлагын нэгжээс Засгийн газрын хүсэлтийн дагуу Ирээдүйн өв сангийн хөрөнгийн менежментийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгч болно.

## **Чиглэл 2: Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, чанартай ажлын байр бий болгох**

### **Зорилго 2.1 Бизнесийн орчныг сайжруулах**

32. **Монгол Улсад бүрэлдэж буй урьдчилан таамаглашгүй орчин нь бизнесийн үйл ажиллагааг хязгаарлаж байна.** Монгол Улс Бизнес эрхлэхүй индексийн хувьд 190 улс орноос 81 дүгээрт жагсаж байна.<sup>15</sup> Хууль, тогтоомжийн хэрэгжилт сул, мэдээллийн, хүртээмж жигд бус байна. Хууль тогтоомж байнга өөрчлөгдөж, үйл ажиллагаа, бизнес эрхлэх орчин тэгш бус, ТӨҮГ-т хандах хандлага давуу байдалтай байдаг. Хөрөнгө оруулагчдыг хамгаалах орчин болон механизм хангалтгүй, тогтворгүй, зохицуулалтын орчин ил тод бус нь байгаа нь хөрөнгө оруулагчдын итгэлийг бууруулж байна. Жишээ нь, Зүүн Азийн бүс нутагтай харьцуулахад Монгол Улсад хувийн хэвшлийнхэн бизнес эрхлэхэд Засгийн газраас гаргасан дүрэм журамтай танилцахад гурав дахин их зардал гардаг.

33. **ЖДҮ-ийн санхүүжилт авах боломж гол асуудал хэвээр байсаар байна.** ЖДҮ эрхлэгчид нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн 98 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд Монгол Улсын нийт ажиллах хүчний тал орчим хувь нь энэ салбарт ажиллаж байна. ЖДҮ-ийг хөгжүүлэхэд санхүүжилт авах боломж болон бизнесийн үйл ажиллагаа явуулах таатай орчин дутагдалтай байгаа нь тулгарч буй гол бэрхшээлүүд болж байна. ЖДҮ-ийн санхүүжилт авах боломжийг хязгаарлаж буй гол асуудлууд нь зээлийн хүү өндөр, хугацаа богино, барьцааны шаардлага хатуу байгаа явдал юм. 2020 оны 10 дугаар сарын байдлаар ЖДҮ эрхлэхэд зориулсан иргэдийн зээлийн хүү дунджаар 16.5 хувьтай, хугацаа нь 18.9 сар, аж ахуйн нэгжийн хувьд хүү нь 12.3 хувь, хугацаа нь 36.1 сар байна. Түүнчлэн, ОУВС-ийн банкны салбарын Активын чанарын үнэлгээний тайланд Монгол Улсын банкны систем тодорхой хэмжээний өндөр эрсдэлүүдийг агуулсан хэвээр байна гэж дурдсан байна.<sup>16</sup> Эдгээр эрсдэлүүдийн улмаас банкуудын зүгээс хувийн хэвшилд олгох зээл олголтоо бууруулж, илүү найдвартай активт оруулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхэд хүрсэн байна. Хувийн хэвшилд олгож буй зээл нь үндсэндээ орон сууцны моргежийн зээл болон хэрэглээний зээлээс бүрдэж байгаа бөгөөд бизнесийн үйл ажиллагаанд зориулсан эсвэл капитал хөрөнгө оруулалтын зориулалттай зээлийн хэмжээ харьцангуй бага байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээл нь санхүүгийн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын хэрэгслийн хувьд төрөлжөөгүй, хөрөнгө оруулагчдын бааз суурь жижиг, зэх зээлийг зохицуулах чадавч харьцангуй сул байна. Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагууд (ББСБ) нь хангалттай хөгжиж чадаагүй байгаа бөгөөд бичил бизнес эрхлэгчдэд олгох санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, лизинг болон даатгалын үйлчилгээ хөгжүүлэх замаар санхүүгийн зах зээлийг цаашид бэхжүүлэх шаардлагатай юм.

34. **Эдийн засгийн өөрчлөлтийг дэмжих нэг гол хүчин зүйл бол хөдөлмөрийн зах зээлийн оновчтой бодлого юм.** Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн үр дүн эдийн засгийн мөчлөг, үр чадварын түвшин ба төрөл, байгалийн улирал, газар зүйн байршлын хувьд тэнцвэргүйн улмаас ажлын байрны үр чадварын эрэлт, нийлүүлэлтийн үл нийцэл, өндөр түвшний ажилгүйдэл, ажиллах хүчний оролцооны бууралт, ялангуяа эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны бууралт зэрэг асуудлууд тулгамддаг. Эдийн засгийн өнөөгийн уналтын үед хөдөлмөрийн зах зээл дэх эдгээр тэнцвэргүй байдал улам мэдрэгдсээр байна. Засгийн газрын зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн үйлчилгээг хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн нийцлийг дэмжих, ажлын байрны хүртээмжийг сайжруулахыг эртнээс зорьж ирсэн. Гэсэн хэдий ч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь нийлүүлэлтийн

<sup>15</sup> Бизнес эрхлэхүй тайлан дахь Монгол Улсын гүйцэтгэл жигд бус байна. Зээл авах (# 25-р байр), барилгын зөвшөөрөл (# 29), цөөнхийн хөрөнгө оруулагчдыг хамгаалах (# 25) зэрэг асуудлыг харьцангуй сайн хийж байгаа боловч төлбөрийн чадваргүй байдал (# 150), цахилгаан авах (# 152) -ийг шийдвэрлэхэд тааруухан байна. ), хил дамнанас арилжаа (# 143) ба бизнес эхлүүлэх (# 100).

<sup>16</sup> Банкны системийн корпорацийн зээлийн 91% -ийг хамарсан Хөрөнгийн чанарын үнэлгээ (AQR) -ийг 2017/18 онд ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд хийсэн. ДНБ-ий хоёр орчим хувьтай тэнцэх хөрөнгийн дутагдлыг тогтоож, банкуудыг 2018 оны эцэс гэхэд хөрөнгөжүүлэхийг хүссэн.

талд ихээхэн ач холбогдол өгч эрэлтийн талыг сул анхаарч ирсэн байна. Амьдралын мөчлөгийн дагуу үр чадварыг хөгжүүлж, сайжруулах асуудал нь институцийн хувьд зохицуулалтгүй, стратеги төлөвлөгөөгүй, бизнесийн салбаруудтай хамтран ажиллах нь дутмаг хэвээр байна.

35. **ДБГ нь бизнес эрхлэх орчин, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл, ялангуяа ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт авах боломжийг сайжруулах, үүнд эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж энэ чиглэлд үзүүлэх дэмжлэгээ үргэлжлүүлнэ.** Ажлын байранд хийх шинэ дүн шинжилгээний үндсэн дээр илүү олон, сайн ажлын байр бий болгох талаар баримтлах бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. ОУСК нь Монголын том дөрвөн банкуудын хоёрт нь хувь эзэмшил болон зээл санхүүжилт олгох замаар хөрөнгө оруулалт хийж, хамтран ажилладаг банкууд болон санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагуудад зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлсэн. ОУСК нь ХААН банк дахь өөрийн хувь эзэмшлээс гараад удаагүй байгаа бөгөөд өөрийн зээлийн шугамаар дамжуулан ЖДҮ-ийг хөдөө аж ахуйн салбарын нийлүүлэлтийн сүлжээнд хамруулах, ногоон зээл, ногоон бонд гаргах чиглэлээр түншлэгч банкуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллана. ББСБ-уудыг хөгжүүлэх, санхүүжилт авах боломжийг сайжруулах үүднээс бичил санхүү, түрээс, даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудтай хамтран ажиллах болно. Үүнтэй холбогдуулан ОУСК-аас томоохон ББСБ-уудын нэг болох Транскапитал ББСБ-д төгрөгийн зээлийн санхүүжилтийг саяхан олгосон бөгөөд энэ нь 15,000 орчим эмэгтэй бизнес эрхлэгчид, бичил болон хөдөө орон нутгийн бизнесүүдэд ашиг тусаа өгөх юм. ОУСК нь Чанаргүй активыг бууруулах хөтөлбөр (DARP)-өөр дамжуулан банк болон ББСБ-уудын санхүүгийн байдлыг сайжруулах, санхүүгийн бэрхшээлтэй тулгараад байгаа ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаагаа зогсоох, дахин зохион байгуулах, бүтцийн өөрчлөлт хийхэд таатай орчинг бий болгох чиглэлээр ажиллана. ОУСК нь одоо хэрэгжиж буй зөвлөгөө өгөх төслөөр дамжуулан санхүүгийн хүндрэлд орсон бизнес эрхлэгчдэд бүтцийн өөрчлөлт хийхэд шаардлагатай тогтолцоог хөгжүүлэх зорилгоор төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор ажиллаж байна. Арилжааны банкуудын зүгээс ЖДҮ болон хямд үнэтэй орон сууц барих төслүүдэд санхүүжилт олгох боломжийг бүрдүүлэхийн тулд эрсдэл хуваалцах хэрэгслийг ашиглаж болох юм. Түүнчлэн, ОУСК нь өөрийн зөвлөгөө өгөх үйлчилгээгээр дамжуулан хамтран ажилладаг банкуудын компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, тогтвортой эрчим хүчний санхүүжилт, цахим шийдлүүд болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх практик үйл ажиллагааг дэмжих болно. Мөн банкны салбар дахь зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, бичил болон ЖДҮ-ийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэхийн тулд Өртгийн сүлжээний (Нийлүүлэлтийн сүлжээний) санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр Монголбанкттай хамтран ажиллана. Түүнчлэн, ОУСК нь ногоон бондын зах зээлийн хөгжлийг дэмжиж, ББСБ-ын салбар, хөрөнгийн зах зээлд тогтвортой санхүүгийн тогтолцоог нэвтрүүлэх / хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Хэрэв Засгийн газар хүсэлт гаргавал ТӨҮГ-ын шинэчлэлд зөвлөгөө өгч, дэмжиж болох юм. Банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Экспортыг хөгжүүлэх төсөл нь ялангуяа эмэгтэй удирдагчтай бизнес эрхлэгчдэд экспортын санхүүгийн бүтээгдэхүүн, чадавхыг дэмжих, бүцэлтгүй тусламж олгох замаар Монголын ЖДҮ-ийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Банкны шинээр байгуулах хөгжлийн бодлогын үйл ажиллагааны хүрээнд хөрөнгө оруулалтын зохицуулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалт болон худалдааг дэмжих бодлого, үйл ажиллагааг дэмжих боломжтой юм. ЖДҮ-дийн зүгээс Засгийн газрын хөнгөлөлттэй санхүүжилтийг илүү сайн ашиглах, мөн хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг дэмжих зорилгоор Банк болон ОУСК нь илүү үр ашигтай санхүүгийн тогтолцоог боловсруулахад хамтран ажиллах боломжтой юм. Банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл нь ажил хайгчид болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах, бичил зээлийн санхүүжилт олгох, бизнес эрхлэх үр чадварыг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлж

байна. Нэмж дурдахад, ОТХОБА нь хувийн хэвшлийг дэмжих, хувийн хэвшлийн шийдлүүдийг эрсдэлээс хамгаалах чиглэлээр Дэлхийн Банк болон ОУСК-тай хамтран ажиллах болно.

## **Зорилго 2.2 Тогтвортой уул уурхай, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих**

36. **Уул уурхайн салбар нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжихэд гол үүрэг гүйцэтгэсээр байх бөгөөд үүнийг илүү тогтвортой, хүртээмжтэй байдлаар удирдан зохион байгуулах ёстой.** Дэлхийн жишигт нийцсэн уул уурхайн томоохон төслийг хөгжүүлэхийн тулд Монгол улс жинтэй гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахаас гадна оруулсан хөрөнгө оруулалтаа тогтоон барихад анхаарах шаардлагатай. Засгийн газрын уул уурхайн хөрөнгийг удирдах чадавх, ялангуяа олон улсын түншүүдтэй хамтарсан үйлдвэр байгуулах хөрөнгийг удирдах чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын уул уурхайн салбарын ирээдүйд байгаль орчны тогтвортой байдал, үүнд ус, эрчим хүчний ашиглалт, орон нутгийн хангамжийн сүлжээг ашиглах, орон нутгийн иргэдэд үзүүлэх үр өгөөж зэрэг нь чухал ач холбогдолтой юм. ДБГ нь уул уурхайн салбарт, ялангуяа ОУСК, ОТХОБА нь Оюу Толгой төслийн томоохон хөрөнгө оруулалтад оролцож ирсэн.<sup>17</sup> Цаашид ОУСК нь ОТ II-р шатны зээл болон бусад уул уурхайн томоохон төслүүдийн талаар хэлэлцэхэд нээлттэй байгаа болно. ОТХОБА-ын баталгаа нь 2027 он хүртэл хүчинтэй байгаа болно. ОУСК-ын зөвлөх үйлчилгээний хүрээнд ОТ төсөлтэй хамтран бизнесийн үр чадварыг дээшлүүлэх, ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг хөнгөвчлөх чиглэлээр Өмнөговь, УБ хотод орон нутгийн ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэх хөтөлбөрийг эхлүүлнэ. Энэ нь ялангуяа уул уурхайн салбарт сэргээгдэх эрчим хүч ашиглах боломжит шийдлүүдийг дэмжихээс гадна төрийн байгууллага хооронд, төр, олон нийт хооронд, ялангуяа уул уурхайн бүс нутагт оршин сууж буй иргэд, түүнчлэн хувийн хэвшил, иргэд хооронд мэдээллийн урсгал, мэдээлэл солилцох үйл явцыг сайжруулах юм. Банкны шинэ техник туслалцаа нь өмнөх хүчин чармайлтад үндэслэн уул уурхайн хөгжлийн ирээдүйн бодлогыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн хувилбаруудыг боловсруулахад чиглэгдэнэ.<sup>18</sup> ОУСК нь "Ил тод байдлаас Хөгжил рүү" хөтөлбөрийн хүрээнд дэд бүтэц, байгалийн нөөцийн салбарт ил тод байдлыг сайжруулах шинэлэг арга хэрэгсэл, арга зүйгээр дамжуулан олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр ажиллах болно. Эцэст нь, ДБГ-ын гишүүн байгууллагууд ОТ- төслийн талаар Засгийн газартай яриа хэлэлцээг үргэлжлүүлэн зохицуулж, бусад хөрөнгө оруулалтын түншүүд, жишээлбэл, Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-тай үргэлжлүүлэн ажиллах болно.

37. **Монгол Улс газар зүйн бэрхшээлээ даван туулах замаар эдийн засгийн өрсөлдөх чадвараа сайжруулахын тулд дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.** Газрын Тээврийн үр ашигтай дэд бүтцийг бүрдүүлэх, түүнийг арчлан хамгаалах нь далайд гарцгүй, уур амьсгалын эрс тэс нөхцөл, хүн амын нягтрал багатай улсын хувьд гол бэрхшээл. Ложистик, тээврийн

---

<sup>17</sup> Олон нийтийн хэлэлцүүлэгт маргаан гарсан хэдий ч энэхүү төсөл нь Монгол Улсад чухал хувь нэмэр оруулсан: \$ 1.6 тэрбумын татварын төлбөр, орон нутгийн худалдан авалтад 2.5 тэрбум доллар, 2010-18 оны хооронд 7.9 тэрбум долларын зардал; 2,649 ажилтан, үүнээс 93% нь Монгол улс; иргэдийн оролцоотой усны менежмент, орон нутгийн худалдан авалт, санхүүжилтийн хүртээмж, ашигт малтмалын сэргээгдэх эрчим хүч, хөгжлийн хөтөлбөрүүдтэй танилцах; хариуцлагатай усны менежментийн чиглэлээр салбартаа тэргүүлдэг Сайн дурын үйл ажиллагааны журам (ОТ-г багтсан уул уурхайн салбарын 13 компанитай тохиролцсон); уул уурхай, газрын доорх усны менежментийн чиглэлээр 1000 гаруй олон нийт, засгийн газар, салбарын оролцогчдыг сургасан; хариуцлагатай уул уурхай, усны менежментийн харилцаа холбооны стратеги, 2018 онд ОТ-ийн орон нутгийн ханган нийлүүлэгчдийг чадавхижуулах, санхүүжилтийн хүртээмжийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж эхэлсэн; Өмнөговьд хамтарсан RE шийдлийн техник, эдийн засгийн үндэслэлийг ОТ болон бусад уул уурхайн компаниудтай хамтран санхүүжүүлсэн.

<sup>18</sup> Банк нь сайжруулсан зохицуулалтын гүйцэтгэл (MSISTAP 2009-15), санхүүжилтийн салбарын мегапроект (MINIS 2011-19) -ын талаархи ТТ-ийн түүхтэй; засаглалын оролцоо (Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС-ын бүцэлтгүй тусламж 2010-2018).

зардал өндөр тул Монгол Улс дэлхийн дэд бүтцийн<sup>19</sup> зэрэглэлийн хувьд бусад орноос хоцорч байна.<sup>20</sup> Дэд бүтцийн чанар сайнгүй байдаг бөгөөд засвар, үйлчилгээ хангалттай бус. Бодлогын хувьд дэд бүтцийн хоорондын хамаарал сайнгүй сонголт, төлөвлөлт, хэрэгжилтийн явц, хөрөнгө оруулалтын болоод зохицуулалтын таатай бус орчин орчин зэргээс шалтгаалан дэд бүтцэд хувийн санхүүжилтийг хангалттай татан авч чадаагүй. Үүний үр дүнд иргэдийн зах зээл, ажлын байр, үндсэн үйлчилгээнд хүрэх хүртээмж хангалтгүй байна. Улаанбаатар хот болон бусад хотын төвүүдийн хотын дэд бүтэц нь оршин суугчдын эрэлт хэрэгцээг хангаж чадахгүйн улмаас эдийн засгийн бүтээмж, амьдралын чанар алдагдахад нөлөөлж, мөн авто машины хэрэглээний өсөлтийн хурд нь Монгол улсын хүлэмжийн хийн тэнцвэрт байдалд нөлөөлж байна. Мөн түүнчлэн, ОХУ болон БНХАУ-тай холбогдож буй эдийн засгийн коридорын нөөц боломжийг бүрэн ашиглаж чадаагүй байна.

**38. ДБГ нь үнэ цэнийн гинжин хэлхээнд анхаарлаа хандуулах замаар дэд бүтцийн тогтвортой хөгжлийг дэмжих болно.** Монгол Улс газарзүйн хувьд бэрхшээл ихтэй, хүн амын нягтаршил багатай тул үнэ цэнийн гинжин хэлхээнд суурилсан зорилтот арга хэмжээг сонгох нь эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бий болгоход амин чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэхүү аргыг ДБГ-ээс саяхан хийж гүйцэтгэсэн Дэд бүтцийн салбарын үнэлгээ (InfraSAP) судалгаагаар танилцуулсан болно. Энэхүү судалгаанд тэргүүлэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг сонгохдоо үнэ цэнийн гинжин хэлхээний аргыг ашиглан, таван стратегийн дэд бүтцийн арга хэмжээг тодорхойлсон ба үүнд мал аж ахуйн үнэ цэнийн гинжин хэлхээ, аялал жуулчлал, үйлчилгээний салбарыг дэмжих хотын хөдөлгөөн, экспортын баримжаатай эрчим хүч ба сэргээгдэх эрчим хүч, ашигт малтмалын үнэ цэнэ, бүс нутгийн холболт зэрэг багтсан болно. Энэхүү судалгаа нь дэд бүтцэд хувийн санхүүжилтийг татах, засаглалын хүрээнд институцийн хуваагдмал байдлыг арилгах арга хэмжээг мөн санал болгосон. Судалгаанд үндэслэн ДБГ санхүүжилтийг сонгосон чиглэлээр буюу мал аж ахуй болон бусад үнэ цэнийн стратегийн гинжин хэлхээний тээврийн холболт, ложистикийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байна. Мөн дэд бүтцийн хангамжийг сайжруулах институцийн чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх болно. ОУСК нь хувийн хөрөнгийг дайчлах, ТХХТ-ийн боломжит шийдлүүдийг судлах болон тээвэр, эрчим хүч, ус/ бохир усны шугам сүлжээний хувьчлалд хамрагдах хөрөнгийг тодорхойлох чиглэлээр салбарын яам, агентлагуудтай үргэлжлүүлэн ажиллана.

**39. Мөн Монгол Улсын эрчим хүчний салбар найдвартай, тогтвортой эрчим хүчний (цахилгаан болон дулаан) нийлүүлэлтийг хангахад ноцтой хүндрэлтэй тулгарч байна.** Монгол Улс сүүлийн хэдэн арван жилийн турш эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийгээгүй бөгөөд өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг хангах нөөц боломжгүй байгаа тул хямрал нүүрлэхэд ойрхон байна.<sup>21</sup> Энэхүү хэрэгцээг хангахын тулд цахилгаан болон төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд нэмэлт хүчин чадал шаардагдаж байгаагаас гадна цахилгаан болон дулаан хангамжийн сүлжээг шинэчлэх шаардлагатай байна. Мөн түүнчлэн, одоогийн эрчим хүчний систем нь нүүрснээс ихээхэн хамааралтай бөгөөд хүлэмжийн хийн ялгаруулалт болон агаарын бохирдол ихсэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Үүний зэрэгцээ, Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний их хэмжээний нөөцтэй хэдий ч маш бага хэмжээгээр ашиглаж байна. Энэ нь Монгол Улс эрчим хүчний шилжилтийг төлөвлөх ёстойг илтгэж байна.

**40. ДБГ-ын эрчим хүчний салбарт оролцох оролцоо нь эрчим хүчний үр ашиг болоод эрчим хүчний шилжилтэд чиглэх болно.** Одоо хэрэгжиж байгаа эрчим хүчний төслүүд цахилгаан түгээх

<sup>19</sup>Жишээлбэл, Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2019-ийг үзнэ үү. Монгол Улс авто замын чанараар 112, зам холболтоор 112, агаарын тээврийн үр ашгаар 117 дугаарт жагсав.

<sup>20</sup> Жишээлбэл, Монгол Улсын 21 аймгаас төмөр зам дөнгөж 7 аймагт хүрдэг бөгөөд 16 нь л нийслэлтэй хатуу хучилттай замаар холбогддог.

<sup>21</sup> Монгол Улс нь Бизнес эрхлэхүй 2020 тайланд Цахилгаан эрчим хүчний индикатороор 152-т жагсжээ.

сүлжээний найдвартай байдлыг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилготой хэрэгжиж байна (ESP2). Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төсөл нь нийслэлийн гэр хорооллын бүсэд шинээр шугам татаж төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээний хамрах хүрээг тэлэх, төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх, агаарын бохирдлыг бууруулах зорилготой хэрэгжиж байна. Үүнээс гадна, ДБГ нь эрчим хүчний шилжилтийн үндэс суурийг тавих, шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоолол хийх болон бодлогын орчныг сайжруулахад аналитик дүн шинжилгээ, зөвлөгөө өгөх зэргээр эрчим хүчний салбарын мастер төлөвлөгөөнд дэмжлэг үзүүлэх юм. Нэмэлт хөрөнгө оруулалтаар нар, салхины сэргээгдэх эрчим хүчийг нэгдсэн сүлжээнд нийлүүлэх чадварыг нэмэгдүүлэх, илүүдэл эрчим хүчийг экспортлох зорилготой системийн шинэчлэл рүү чиглэх юм. ОУСК нь сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтыг дэмжих боломжийг судлах, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хэрэгжилт, санхүүгийн байгууллагын уур амьсгалын стратегид зөвлөмж өгөх зэргээр дэмжлэг үзүүлнэ. Мөн Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг улс төрийн эрсдэлийн баталгаагаар дамжуулан эрчим хүчний салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бэхжүүлэх боломжийг судлах юм. Эдгээр арга хэмжээнүүд нь Парисын уур амьсгалын өөрчлөлтийн бага хурлын үеэр тохиролцсон Монгол Улсын “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр”-ийн зорилгуудтай нягт уялдаж байна.

41. **Дэлхийн Банк нь дижитал холболт болон дижитал эдийн засгийн үндэс суурийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.** Дижитал шилжилт Монгол Улсад эрчимжиж<sup>22</sup> байгаа төдийгүй КОВИД-19 цар тахал энэхүү чиг хандлагыг хурдасгаж байна. Засгийн газар e-Mongolia санаачилгыг долоон жилийн дотор хэрэгжүүлэх зорилт тавьсан бөгөөд төрийн 181 төрлийн үйлчилгээг e-Mongolia нэгдсэн порталаар дамжуулан цахимаар авах боломжтой нэвтрүүлээд байна. Мөн түүнчлэн 2015 онд батлагдсан Ухаалаг засаг төсөл нь төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдал, үр ашгийг сайжруулахад мэдээлэл, харилцааны холбооны технологийг ашиглах зорилгоор хэрэгжиж байна. Энэхүү төсөл нь нээлттэй өгөгдлийн портал, төрийн нэгдсэн энтерпрайз архитектур, үндэсний дата төвийн нөөц төв, өмчийн бүртгэлийн систем болон 30 гаруй төрийн үйлчилгээг иргэд болоод аж ахуй нэгжүүдэд зориулан цахимжуулах зэрэг цахим засаг, төрийн үйлчилгээний үндсэн суурийг тавьсан юм. Одоогийн хүрсэн үр дүн, эрх баригчдын нэвтрүүлээд буй e-Mongolia санаачилгад тулгуурлан Дижитал шилжилт төслийг ирээдүйд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь иргэд, аж ахуй нэгжид зориулсан төрийн үйлчилгээний цахим шилжилтийг хурдасгах, КОВИД-19 цар тахлын үед зайлшгүй ач холбогдолтой болж байна.

### **Зорилт 2.3. Уул уурхайгаас бусад салбарын бүтээмж, хот суурин газрын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх**

42. **ДБГ нь Монгол Улсын уул уурхайн бус салбарын хөгжил, тэр дундаа ажлын байр шинээр бий болгох салбарууд болон эмэгтэйчүүдэд тусгайлан анхаарлаа хандуулж дэмжлэг үзүүлнэ.** Хөдөө аж ахуйн салбар нь эдийн засгийг солонгоруулах хөшүүрэг болох төдийгүй өргөн хүрээтэй хөдөлмөр эрхлэлтийн гол эх үүсвэр юм. Хөдөө аж ахуйн салбар нь хүн амын гуравны нэг орчмыг ажлын байраар хангаж, ДНБ-ний 13 хувийг эзэлж байна. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд мах, сүү зэрэг малын гаралтай үндсэн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин 90 хувьтай байна. Гэвч арилжааны шинж чанартай мал аж ахуй, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоо дутагдалтай байдал нь уг салбарын бүтээмжийг бууруулаад зогсохгүй хууль эрхзүйн зохицуулалтын сул тал

---

<sup>22</sup> Харилцаа холбооны зохицуулах хорооны Монгол Улсын мэдээллийн технологийн салбарын талаар гаргасан хамгийн сүүлийн тайланд 2010 онд 200,000 хэрэглэгчтэй байсан интернэтийн үйлчилгээ 2016 оны 12-р сар гэхэд 2.6 сая болж интернетийн нэвтрэлтийг 86 хувьд хүргэсэн талаар дурджээ. Гар утас, ухаалаг утасны хэрэглээ 2009 онд хүн амын 60% байсан бол 2015 онд 102% болж өссөн байна.

Монгол Улсыг экспортын зах зээлд нэвтрэх боломжийг чөдөрлөж байна. ДБГ-ын сүүлд хийсэн судалгаагаар аялал жуулчлал, тээврийн үйлчилгээ, ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн нь Монгол Улсын харьцангуй давуу тал байх боломжит салбарууд гэж тодорхойлсон ч ложистик, санхүүгийн нөөц, зохион байгуулалтын тулгамдсан асуудлууд шийдэгдээгүй хэвээр байна.<sup>23</sup> Ялангуяа, аялал жуулчлалын салбар ДНБ-ний 11.8%, ажил эрхлэлтийн 9 хувийг (2018) эзэлж байгаа нь цаашид өргөжих боломжтойг илтгэж байна.

**43. Хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгоход ДБГ дэмжлэг үзүүлнэ.<sup>24</sup>**

- Мал аж ахуйн салбарын хувьд Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл 2020 оны төсвийн жилд батлагдаж, хэрэгжиж эхэлсэн бөгөөд малын эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, мал аж ахуй газар тариалангийн бүтээмжийг нэмэгдүүлэх, арилжааны үйл ажиллагаа, дэд бүтцийг бэхжүүлэх чиглэлд ажиллах юм. Түүнчлэн, чухал үүрэгтэй төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүй байдлын стандартыг сайжруулах, аж ахуй нэгжүүдийн тэр дундаа эмэгтэй удирдагчтай аж ахуй нэгжийн бүтээмж, бизнесийн үйл ажиллагааг бэхжүүлэх замаар хувийн хэвшлийн оролцоог тэлэх нөхцөлийг бүрдүүлэх юм. Төслөөс хэрэгжүүлэх арга хэмжээ үр дүнтэй нь батлагдвал төслийн санхүүжилтийг нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх эсхүл бусад салбаруудад мөн адил төрлийн дэмжлэг үзүүлэх талаар судлан үзэх болно. Цаашид, Монгол улсын хөдөө аж ахуйн гаралтай хүнсний үйлдвэрлэлийн тогтолцоог өөрчлөх чиглэлээр үнэлгээ шинжилгээний судалгаа хийснээр хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, төсвийн зардлыг (ялангуяа татаас болон бусад дэмжлэгийн хөтөлбөрүүдийг) дахин хянаж үзнэ. Мөн Дэлхийн Банкны Хөгжлийн бодлогын үйл ажиллагаа /ХБҮА/ нь бэлчээрийг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлттэй уялдсан ухаалаг хөдөө аж ахуйг бэхжүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг дэмжих боломжтой. ОУСК ба ОТХОБА нь мах, махан бүтээгдэхүүн, цагаан идээ, ноолуур гэх мэт ирээдүйд өргөжих, экспортлох боломж харьцангуй өндөр магадлалтай, үнэ цэнэ бүхий сегментүүдийг сонгон хамтран ажиллана. ОУСК нь Банкны Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөлтэй хамтран хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах чиглэлээр үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ.
- ОУСК аялал жуулчлалын салбарт зочид буудлын зах зээлийн дээд зэрэглэлийн (Шангри-Ла зочид буудал) болон дунд зэрэглэлийн (Ибис Стайлс) сегментэд өмнө үзүүлсэн дэмжлэгийг үргэлжлүүлнэ. Цаашид Улаанбаатар хотоос гадна байрших төслүүдэд мөн анхаарч байгальд ээлтэй аялал жуулчлалаар дамжуулан хөдөө орон нутагт ажлын байр бий болгох, орлогыг нэмэгдүүлэх төслүүдийг дэмжин ажиллана. Хэрвээ засгийн газрын зүгээс хүсэлт байвал ОУСК-ийн ТХХТ-ийн зөвлөх үйлчилгээний баг үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК-ийг төр хувийн хэвшлийн түншлэлийн замаар хувьчлах асуудлыг судалж үзэх боломжтой. Дэлхийн Банк нь “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого 2019-2026”-ын хэрэгжилт, Монгол Улсын аялал жуулчлалын салбарын өсөлтийг дэмжих зорилгоор Хүртээмжтэй Аялал жуулчлалыг Хөгжүүлэх үнэлгээ шинжилгээний судалгаагаар дамжуулан бодлогын арга хэмжээ болон шаардагдах хөрөнгө оруулалтыг тусгайлан тодорхойлох болно.

<sup>23</sup> ОУСК, 2017, *Монгол Улсын боломжийн судалгаа*, Latimer, Julian and Marcin Piatkowski, 2018, *Ноолуур, ноос, мах, арьс ширний салбарын худалдаа, тээврийн үйл ажиллагааны үнэлгээ ба Монгол Улс дахь эдийн засгийн төв коридорын боломж*, Бодлогын баримт бичиг, Дэлхийн Банк.

<sup>24</sup> Мөн түүнчлэн эдгээр салбарт чиглэсэн арга хэмжээнүүдэд бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр хийгдэж буй хүчин чармайлт болон Экспортыг дэмжих төслийн хүрээнд уул уурхайн бус салбарын ЖДҮ-ийг дэмжих, тэдгээрийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор хэрэгжиж байгаа арга хэмжээнүүд хувь нэмэр оруулах болно.

44. **Нийслэл, хот суурин газрууд нь Монгол Улсын өсөлтийн гол түлхүүр бөгөөд ДБГ хотын өрсөлдөх чадвар, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.** Монгол Улсад хот, суурин газрын хүн ам 2000 онд 57 хувийг эзэлж байсан бол 2018 онд 69 хувь болсон бөгөөд үүний 46 хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байна. Монгол Улсын ДНБ-ний 73 хувийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт гэсэн гурван хот бүрдүүлж байна. Хот суурин газрын тэлэлтийг зохицуулахын зэрэгцээ, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг сайжруулах, ялангуяа агаарын бохирдлыг бууруулах, хотын дэд бүтэц болон үйлчилгээний тэгш бус хүртээмжийг сайжруулах зэрэг нь Монгол Улсын хотуудад тулгараад буй гол бэрхшээлүүд юм. Дэлхийн Банкны зүгээс гүйцэтгэж буй Монгол Улсын хотууд ба уур амьсгалын өөрчлөлтийн судалгаанд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын сценарийн шинжилгээ болон ЖДҮ-ийн техник судалгаанд үндэслэн, уг гурван хотын өсөлт, уур амьсгалын өөрчлөлтийг голлон судалж байна. Уг судалгаанд тулгуурлан хотын өрсөлдөх чадвар, нөхөн сэргээлтийн төсөл нь хот суурин газрын арьс шир, ноос боловсруулах салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хот суурин газрын хөрсний эвдрэлийг нөхөн сэргээх, усны чанарыг сэргээхэд дэмжлэг үзүүлэх боломжтой юм. Улаанбаатар хотын зам, тээврийн салбарт тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд хотын сонгогдсон гол зам, тээврийн коридорын аюулгүй байдал, цаг агаарын гаралтай эрсдэлийг даван туулах чадавх, тогтвортой байдлыг сайжруулах чиглэлээр Дэлхийн Банкны санхүүжилтийг ашиглах боломжтой юм. Уг хамтын ажиллагаа нь өнгөрсөн жилүүдэд хэрэгжсэн хотын зам, тээврийн салбарын хэд хэдэн техникийн туслалцаа, судалгаанд тулгуурлах болно. Мөн орон сууцжуулалт, хог хаягдлын менежментийн чиглэлээр хамтран ажиллах боломжтой юм. ОУСК нь төлбөрийн чадварт нийцсэн, эко орон сууцжуулалтад хөрөнгө оруулах боломжийг эрэлхийлэх болно. Ингэхдээ АХБ-ны гэр хорооллын дахин төлөвлөлтийн санаачилгатай хамтран, орон нутгийн түвшинд санхүүжилтийн шийдлүүдийг боловсруулахад Улаанбаатар хоттой хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулалт болон ногоон санхүүжилтийг дэмжих зорилгоор арилжааны банкуудтай эрсдэл хуваах хэрэгслүүдийг хөгжүүлэх болно. ОУСК нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад зориулж ногоон барилгын стандарт, эрчим хүчний хэмнэлттэй төслүүдийг боловсруулахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ. Мөн түүнчлэн газрын харилцаа, газарзүй-орон зайн мэдээллийн менежментийн чиглэлээр Дэлхийн Банкны хэрэгжүүлсэн ажлууд нь хотын менежмент, тээвэр болон бусад салбар дахь боломжуудыг нээх боломжтой юм.

### **Чиглэл 3: Хүмүүн капиталыг өргөжүүлэх ба амьдралын чанарыг сайжруулах**

#### **Зорилт 3.1 Эрүүл мэнд болон боловсролын чанартай үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (Үүнд КОВИД-19 цар тахлын эрүүл мэндийн хариу арга хэмжээ багтсан болно)**

45. **Монгол Улсад эрүүл мэнд, боловсролын салбарт чанартай үйлчилгээ үзүүлэхэд асуудал тулгарч байна. Эрүүл мэндийн салбарын** хувьд тусламж үйлчилгээний чанар, ялангуяа хөдөө орон нутгийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар гол тулгамдсан асуудал болоод байна. Үзүүлж буй үйлчилгээ нь техникийн болон хуваарилалтын хувьд үр ашиггүй байгаа бөгөөд эрүүл мэндийн тогтолцоо нь Монгол улсад нас баралт, өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болоод байгаа Халдварт бус өвчний өсөн нэмэгдэж буй ачааллыг даахуйц биш байна. Дэлхийн 195 орны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарын судалгаагаар Монгол Улс дөнгөж 119-р байранд бичигджээ.<sup>25</sup> Монгол Улс төсвийн зардлыг үр ашигтай зарцуулах замаар өндөр чанартай үйлчилгээ үзүүлэх тогтолцоонд шилжих шаардлагатай байна. КОВИД-19 цар тахал нь нийгмийн эрүүл мэндийн тогтолцооны сул талыг улам илрүүлж, өвчний хяналтын илүү хүчирхэг тогтолцоог бий болгох, олон

<sup>25</sup> 195 орны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж ба чанарын үзүүлэлт: Global Burden of Disease Study –ийн 2016 онд хийсэн тогтолцооны дүн шинжилгээ.

нийтийн бэлэн байдлыг бэхжүүлэх шаардлагатайг харуулж байна. **Боловсролын салбарт** хэдийгээр Монгол Улс их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа боловч сургалтын үр нөлөө, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэгдсэн байдал зэрэг хөрөнгө оруулалтын үр өгөөжийн хувьд хоцрогдолтой байна. Мөн бага насны хүүхдийн унших, тоо бодох чадвараар ижил эдийн засагтай орнуудтай харьцуулбал Монгол Улс доогуур жагсаж байна.<sup>26</sup> Монгол Улсын бага насны ба бага ангийн хүүхдүүдийн дунд чадварын ялгаа их байгаа төдийгүй цаг хугацаа өнгөрөх тусам ялгаа нь нэмэгдэх хандлагатай байна.<sup>27</sup> Чанарын зөрүүг арилгах нь нэн чухал боловч үндэсний сургалтын үнэлгээ хийдэггүй, цалингийн бус үйл ажиллагааны төсөв бага, сургуулийн түвшний бие даасан байдал хангалтгүй, хөдөө орон нутагт ялангуяа хурч үйлчлэхэд хүндрэлтэй хүн амд чиглэсэн зорилтот үйлчилгээ дутмаг зэрэг нь байдлыг улам хүндрүүлж байна. Нийгэм-сэтгэл зүйн үр чадварт үзүүлэх дэмжлэг дутмаг, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдаа холбоогүйгээс Монгол Улсын эдийн засагт нийцэхүйц үр чадварыг хөгжүүлэхэд улам саад учруулж байна. Энэ нь үндэсний хэмжээнд залуучуудын ажиллах хүчний оролцооны түвшин бага, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (МСҮТ)<sup>28</sup>, их дээд сургууль төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин бага байгаагаар нотлогдож байна.

46. **ДБГ-ээс одоо хэрэгжүүлж байгаа болон цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд эрүүл мэнд, боловсролын салбарыг дэмжих болно.** КОВИД-19 цар тахлын эсрэг **нийгмийн эрүүл мэндийн** хариу арга хэмжээг дэмжих зорилгоор КОВИД-19 цар тахлын эсрэг ДБГ-ийн түргэвчилсэн санхүүжилтээр (FTCF) хэрэгжүүлэх КОВИД-19 Стратегийн бэлэн байдал ба хариу арга хэмжээний хөтөлбөрийн нэг хэсэг болгон онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах, эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлыг хангахад зориулсан хоёр төслийг 2020 оны санхүүгийн жилд шуурхай баталсан. Энэхүү хоёр багц арга хэмжээ нь вакцины санхүүжилт болон нийгмийн эрүүл мэндийн бэлэн байдлын үндэсний тогтолцоог бэхжүүлэх замаар КОВИД-19 цар тахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ авах Монгол Улсын чадавхийг бэхжүүлэх зорилготой. Одоо хэрэгжиж буй Цахим эрүүл мэнд төсөл нь өвчтөний мэдээллийг бодит цагаар солилцох үйл ажиллагааг хөнгөвчлөх, халдварт бус өвчнийг (ХБӨ) хянахад шаардагдах үнэн зөв, бодит цаг үеийн мэдээллээр хангах замаар ХБӨ-ний үр ашигтай хяналт, удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм. **Боловсролын салбарын хувьд**, одоо хэрэгжиж буй Боловсролын чанарын шинэчлэл төсөл нь бага ангийн боловсрол, сургалтын үр нөлөө, багшийн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, хүүхэд, залуучуудын тодорхой бүлгүүдийн боловсролын хүртээмжийг дээшлүүлэх, тэдний зорилтот үр чадварыг хөгжүүлэх зорилготой юм. 2020 оны 6 дугаар сард бүтцийн өөрчлөлт хийснээр КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалтай цаашид уялдуулан цахим сургалтын платформ хөгжүүлэх, цахим боловсролын агуулга, багшийн мэргэжлийн хөгжил, хүртээмжтэй боловсрол, сургуулийн удирдлагыг сайжруулах болон алслагдсан хөдөө орон нутгийн иргэдэд хүрэх боломжууд зэрэгт төслийн үйл ажиллагаа илүү чиглэх болно. Нийгмийн хөгжлийг дэмжих Япон сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй ХАТХИС (Хүлээн авагч талын хэрэгжүүлэх итгэлцлийн сан) хөтөлбөр нь сонгосон аймгуудын ядуу, эмзэг бүлгийн залуучуудад сургуульдаа амжилттай суралцах, хөдөлмөрийн зах зээлд ялангуяа хувиараа хөдөлмөр эрхлэхэд бэлтгэгдэх нийгэм-сэтгэл зүйн үр

---

<sup>26</sup> Монгол Улсад 3-5 настай хүүхдийн 9 хувь нь л ангийн унших, тоолох даалгаврыг гүйцэтгэж чадаж байна. Гэтэл Тайланд, Уругвай, Беларус, Украин, Македон, Аргентин, Серб, Молдав зэрэг улсад энэ үзүүлэлт 30-69 хувьтай байна. Энэ тоо баримтыг “Монгол Улс: Бага нас” зөвлөх үйлчилгээний тайлан бичсэн зохиогчдын нэгтгэсэн мэдээлэлд тулгуурлан гаргав (Дэлхийн Банк, удахгүй хэвлэгдэнэ).

<sup>27</sup> Дэлхийн Банк. 2017. Монгол Улсын СӨБ: Үйлчилгээний хүртээмж ба чанар, хүүхэд хөгжлийн үр дүн – 2017 оны 3-р сар (Англи хэлээр). Вашингтон хот: Дэлхийн Банк Групп.

<sup>28</sup> 2012 онд МСҮТ төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин төгссөнөөс хойш зургаан сарын дараа 55.6 хувьтай байна (АХБ. 2014. НБГ-ын салбарын үнэлгээ: Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын төсөл.) Монгол Улсад МБС-ын болон анхан шатны үр чадварын сургалтын үүргийг чухалчлан үздэггүй. эрдмийн урсгал ба сахилга бат. Энэ нь үр чадвар ба бэлэн ажлын байрны хоорондын зөрүүг улам бүр нэмэгдүүлэхэд хүргэдэг.

чадвар эзэмшүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой.<sup>29</sup> Засгийн газрын зүгээс эрүүл мэнд болон боловсролын салбарт нэмэлт шинэчлэлүүдийг хийхэд Дэлхийн Банкны зүгээс хүчээ дайчлан, шуурхай хамтран ажиллахад бэлэн байна.<sup>30</sup>

### **Зорилт 3.2: Нийгмийн хамгааллын тогтолцооны үр ашиг, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх**

47. **Нийгмийн хамгааллын үр ашигтай, тогтвортой тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр дорвитой ахиц дэвшил гаргах шаардлагатай байна.** Хэдийгээр Монгол Улс ДНБ-ий 2-оос дээш хувийг нийгмийн халамжид зориулж байгаа ч үүний багахан хэсэг нь КОВИД-19 цар тахал зэрэг эдийн засгийн болон нийтийг хамарсан цочрол, хямралд хамгийн их өртдөг ядуу, эмзэг бүлгийнхэнд очдог. Нийгмийн халамжийн дэмжлэг, үйлчилгээний ихэнх нь ядуучууд гэхээс илүү тухайлсан бүлгүүдэд зориулагддаг бөгөөд нэн ядуу иргэдэд чиглэсэн дэмжлэг ядуурлаас гарахад нь тусалж чаддаггүй. Засгийн газар “өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-г ашиглан орлогыг орлуулан тооцох аргачлалаар (Proху-Means Test) ядуу өрхийг тодорхойлох боломжтой хэдий ч энэхүү аргыг өргөн хүрээнд ашиглахгүй байна. Тэтгэврийн тухайд бол, тэтгэврийн зардлын санхүүжилтэд улсын төсвөөс олгодог татаасын хэмжээ тогтворгүй түвшинд хүрэхэд тун ойрхон байна. КОВИД-19 цар тахлын үед түр хугацаагаар нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцахаар болсон нь эдийн засагт бодитой дэмжлэг болсон хэдий ч ихээхэн өртөгтэй арга хэмжээ юм. “Онцгой байдлын дэмжлэг ба хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд КОВИД-19 цар тахлын нөлөөг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан шаардлага хангасан хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын шимтгэлээс түр хугацаанд чөлөөлөхөд дэмжлэг үзүүлсэн. Тэтгэврийн зардлыг санхүүжүүлэхэд зориулсан төсвийн татаасын өсөлтийг хязгаарлах, даатгуулагчийн тэтгэврийн хэмжээг зохистой түвшинд байлгахын тулд тэтгэврийн тогтолцоонд параметрийн шинэчлэлийг нэн даруй хийх шаардлагатай байна.

48. **Засгийн газраас нийгмийн халамжийн хөтөлбөр, тэтгэвэр, нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэхэд нь Дэлхийн Банкнаас үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ.** Дэлхийн Банк нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хөгжүүлсэн түншлэлийн үндсэн дээр нийгмийн халамжийн тогтолцоог шинэчлэх Засгийн газрын хүчин чармайлтыг дэмжин ажиллах болно. Мөн Дэлхийн Банк нь нийгмийн халамжийн хөтөлбөрийг ядуу, эмзэг бүлгийнхэнд чиглүүлэн өөрчлөх хүчин чармайлтыг үргэлжлүүлэн дэмжинэ. Үүнд, хууль тогтоомжийн шинэчлэлийн төсөлд бодлогын зөвлөгөө өгөх, нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг нэгтгэх, өрхийн мэдээллийн сан, зорилтот бүлгийг тодорхойлох тогтолцоог бэхжүүлэх, цочролд хариу арга хэмжээ авах, дасан зохицох хөтөлбөрийн суурийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Нийгмийн хамгааллыг бэхжүүлэх нь шинээр хэрэгжүүлэхээр зэхэж буй ХБҮА-ны нэг гол хэсэг байх бөгөөд үүнд нийгмийн халамжийн бодлогыг дэмжих асуудал ч мөн багтана. Банк нь тэтгэврийн даатгалын тогтолцоо, нийгмийн даатгалын бусад хууль тогтоомж, хөтөлбөрийг шинэчлэх, тэтгэврийн даатгалын тогтолцооны санхүүжилтийн тогтвортой байдлыг сайжруулах, нийгмийн даатгалын хөтөлбөрийн тэгш байдал, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ.

### **Зорилт 3.3 Амьжиргааг сайжруулах, хүрээлэн буй орчин, уур амьсгалыг хамгаалах**

<sup>29</sup> Дээд боловсрол, бие даасан байдал, хариуцлага хүлээх чадвар, компаний засаглал, эмзэг бүлгийнхний тэгш оролцоо, хүртээмж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд чиглэсэн АХБ болон бусад хандивлагчдын нэмэлт хөрөнгө оруулалт.

<sup>30</sup> Олон Улсын Боловсролын Түншлэлийн дэмжлэгтэйгээр боловсруулсан боловсролын салбарын дүн шинжилгээнд сургалтын үр дүн сул, нийгэм эдийн засаг болон газарзүйн ялгаатай байдал, үр ашиггүй хуваарилалт, сургалтын хөтөлбөр зэрэг хүндрэлтэй талуудад дүн шинжилгээ хийж, нээлттэй, алсын зайн, цахим болон уян хатан сургалтын арга замыг боловсруулах замаар сургалтын чанарыг сайжруулах Засгийн газрын Боловсролын стратеги дэмжлэг үзүүлсэн.

49. **Эцэст нь хөдөө орон нутгийн амьжиргааг сайжруулах, байгаль орчныг хамгаалах нь монголчууд, тэр дундаа ядуу, эмзэг бүлгийн хүмүүсийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.** Монгол Улсын газар зүйн бэрхшээлтэй байдлаас шалтгаалан хөдөө орон нутагт үйлчилгээг чанартай, боломжийн өртгөөр хүргэх нь бэрхшээлтэй байдаг. Цаг агаар, уур амьсгалын цочролд өртөмтгий байдлыг бууруулах, амьжиргааны сонголтыг өргөжүүлэх нь чухал байна. Монгол Улс нь хүрэн нүүрсэнд суурилсан эрчим хүчнээс хамаарал ихтэй, бэлчээрийн мал аж ахуй, услалтын системгүй газар тариалан эрхлэлдэг, хүн амын ихэнх нь цөөн тооны хот суурин газарт төвлөрч байгаа нь Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжлийг байгаль орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөд маш их өртөмтгий болгож байна. Иймд Монгол орны цэвэр агаар, ус, өргөн уудам бэлчээр, байгалийн унаган төрхийг хадгалахад хүрээлэн буй орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн бэрхшээлийг шийдвэрлэх нь зайлшгүй шаардлагатай юм. Энэ нь өнөөгийн монголчуудын болоод ирээдүй үеийн амьжиргааны сайн сайхан байдалд шууд холбоотой юм. Монгол Улс Парисын хэлэлцээрт нэгдэн орсон бөгөөд “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” (ҮТХН)-ийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Энэхүү үүрэг нь 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтыг 4 хувиар бууруулах зорилго юм.

50. **ДБ нь орон нутгийн түвшинд амьжиргааг сайжруулах зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх болно.** Банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Тогтвортой амьжиргаа - 3 төсөл нь эцсийн хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилгоор Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-д дэмжлэг үзүүлж, орон нутаг, хөдөөгийн иргэдийн амьжиргааны боломжийг сайжруулахад дэмжлэг үзүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь удаан хугацаанд үргэлжлэн хэрэгжиж байгаа. Банкны дэмжлэгтэйгээр ОНХС нь орон нутгийн иргэдийн сайтар мэддэг тэргүүн эгнээний хөтөлбөр болсон. Мөн орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтэд олон нийтийн оролцоог хангах, эрсдэлийг даван туулах чадварыг сайжруулах, эдгээрт эмэгтэйчүүдийг оролцоо, манлайллыг хангах зэрэг нь тус хөтөлбөрийн нэн чухал шинж чанар юм. Засгийн газрын зүгээс ОНХС-гийн энэхүү түршлагыг цаашид аймаг болон УБ хотын түвшинд өргөжүүлж үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хүсэлт тавиад байгаа. Энэ чиглэлд Банкны цаашдын оролцоог үр дүнд суурилсан хөтөлбөр (P4R)-ын хэлбэрээр төлөвлөж болох юм.

51. **ДБГ нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь олон салбарыг хамрах бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох асуудлыг хоёуланг нь авч үзнэ. Энэ нь хүлцэх байдлын үйл ажиллагааны төв нь юм.**

- Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах чиглэлд Банкнаас дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ (i) эрчим хүчний үр ашиг; (ii) сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлж эрчим хүчний хосолмол хэлбэрийг төрөлжүүлэх; ба (iii) институт, эрх зүйн зохицуулалт, бодлогын шинэчлэлийн чиглэлд бодлогын яриа хэлэлцээ хийх. Эдгээр үйл ажиллагаа нь Монгол Улсын ҮТХН-ийн амлалттай нягт уялдана. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд нарны эрчим хүчний үүсгүүрийн технологи, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлсэн Эрчим хүчний салбарын төсөл юм. Түүнчлэн уламжлалт халаалтын зуухыг илүү үр ашигтай хувилбараар сольж, Монгол Улсын уур амьсгалын нөлөөллийг бууруулах ажлыг дэмжиж буй Улаанбаатар цэвэр агаар төсөл (УБЦАТ), халаалтын үр ашгийг дээшлүүлж, утааг бууруулах зорилготой Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төсөл мөн хэрэгжиж байна. Халаалтын илүү оновчтой хувилбаруудыг бий болгох, сэргээгдэх эрчим хүчийг өргөжүүлэх, нийтийн тээврийг сайжруулах замаар уур амьсгалын нөлөөллийг бууруулах хэд хэдэн үнэлгээ, шинжилгээний ажлыг гүйцэтгэхээр зорьж байна. ОУСК нь сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийж, ногоон барилгын шийдлүүдийг дэмжих, энэ салбарт хөрөнгө оруулалт, арилжааны

болон ногоон моргежийн зээлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллах бол ОТХОБА нь хил дамнасан хөрөнгө оруулалтын боломжуудыг судлах болно.

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход Банкнаас барьж буй стратеги чиглэлд: (i) уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хот; (ii) чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын ҮТХН-ийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ. Одоо хэрэгжиж байгаа төсөл: Гамшгийн эрсдэлийг бууруулах, нөхөн сэргээх олон улсын сан (GFDRR) болон ҮТХН-ийг дэмжих байгууллагын Итгэлцлийн сангуудаас санхүүжиж буй Монгол орны уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хотын хөгжлийн талаарх үнэлгээ шинжилгээний судалгаа орно. Энэхүү зөвлөх үйлчилгээ, дүн шинжилгээний хүрээнд Дэлхийн Банк нь Монгол Улсын ҮТХН-ийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлнэ. Түүнчлэн, уур амьсгалын ногоон санхүүжилт, хувийн хэвшлийн санхүүжилт, хөгжлийн бусад түншүүдтэй хамтран санхүүжүүлэх зэрэг санхүүжилтийн бусад эх үүсвэрийг ашиглахыг зорьж байна.
- Усны салбарт Банк нь 2030 усны нөөцийн бүлгээр дамжуулан бат бөх суурийг тавьж, усны нөөцийн болон бохирдлын менежмент, хот суурины усны тарифын шинэчлэл, сав газрын засаглал, хаягдал бохир усыг цэвэрлэн эргүүлэн болон дахин ашиглах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, уул уурхайн усны менежмент, усны нөөцийн үнэлгээ, урамшууллын механизм бий болгох зэрэг еусны эрэлт нийлүүлэлтийн зөрүүтэй байдлыг арилгах, хаягдалгүй эдийн засаг, оролцогч талуудыг идэвхжүүлэх чиглэлээр зөвлөмж, дүгнэлт, дүн шинжилгээг хийгээд байна. Цаашид эдийн засгийн эргэх холбоо шийдлүүд, ландшафтын нэгдсэн менежмент, ус, голын сав газрын менежмент, хатуу ба хуванцар хог хаягдлын менежментийн талаар цаашид хийх ажлуудыг судлах болно.

## Нийтлэг асуудлууд

### Засаглал

52. **Монгол Улс сүүлийн арван жилд засаглалын олон чиглэлд нэлээд ахиц дэвшил гаргасан хэдий ч иргэдэд хүрсэн үр дүнг бий болгоход засаглалыг улам бүр сайжруулах, гаргасан ахицыг бүрэн институцлэхэд хэд хэдэн бэрхшээл тулгарсаар байна.** Төсөв, нийгэм, байгаль орчин, санхүүгийн салбарын удирдлага, хариуцлагын тогтолцоотой холбоотой харилцааг үндэсний болон орон нутгийн түвшинд зохицуулах хууль эрхзүйн зохистой орчин бүрдсэн. Гэсэн хэдий ч эдгээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дагаж мөрдүүлэхэд хоцрогдол гарч байгаа нь үр дүнг хязгаарлаж байна. Эдгээр сүл талуудад i) сонгуулийн үеэр популист бодлогын амлалт өгөх хандлага, ii) бодлогын дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээг хангалттай түвшинд хийлгүйгээр хууль батлах үйл явц, болон iii) парламент дахь олонх ойр давтамжтай өөрчлөгдсөнөөс үүдэлтэй төрийн бодлого, төрийн албаны залгамж чанарт нөлөөлөхүйц улс төрийн шинж чанартай төрөл бүрийн авилга зэрэгтэй холбоотой.

53. **Засаглалын алдаа дутагдал нь төрийн албаны чадавх, төсвийн үр ашиг, хууль эрх зүйн зохицуулалт, тогтолцооны үр нөлөө, иргэдийн оролцоо, хөрөнгө оруулагчдын итгэлд сөргөөр нөлөөлж байна.** Монгол Улсын төрийн албаны чадавх жигд бус, улсын салбарт үе шат бүрт улс төржилт ихэсч байна. Төрийн албанд ахлах албан тушаалтны халаа сэлгээ түгээмэл байгаа нь улсын салбарын үр нөлөөг бууруулж, томорсон төрийн алба холбогдох цалингийн сангийн зардлын өсөлт нь улс орны төсвийн тогтвортой байдалд үзүүлэх эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна. Шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах хууль эрх зүйн орчинг бэхжүүлэх, арга замуудыг хэвшүүлэх чиглэлд арга хэмжээ авч хэрэгжүүлсэн хэдий ч олон нийтийн оролцоо доогуур хэвээр байна. Түүнчлэн, ил тод байдал, хариуцлагыг хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа ялгаатай үр дүнгүүдэд

хүргэсэн.<sup>31</sup> МХХТ-ийн шийдлүүд ил тод байдал, төрийн үйлчилгээг сайжруулахад нөлөөлж болох талтай. Технологийн боломжит чадавхыг нээхийн тулд Монгол Улс цахим засаглалын эрх зүйн орчныг сайжруулах, цахим хэрэглээний ялгамжтай байдлыг багасгах, иргэдэд зориулсан цахим апп, цахим үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай байна.

**54. Засаглал бүхий л салбарт нийтлэг асуудал учир энэ чиглэлд ДБГ-ын оролцоо ТСХ-ний гурван тулгуурт бүгдэд хамаарна.** Эдийн засгийг удирдах институциуд, бизнесийн орчин, төрөөс үзүүлэх үйлчилгээ болон иргэдийн оролцоо зэргийг бэхжүүлж сайжруулах асуудал ДБГ-ын бүх тулгуур чиглэл дэх оролцоонд хамаарна. Төслийн түвшинд улс төрийн нөлөөллийн дүн шинжилгээ хийх нь төслийн дизайн, хэрэгжүүлэх зохицуулалтуудыг тодорхойлоход дэмжлэг үзүүлнэ. Уг арга хандлага нь ДБГ-ын Монгол улсад засаглалын асуудлуудаар хуримтлуулсан өмнөх туршлага дээр үндэслэнэ. Одоо хэрэгжиж буй зарим төсөл, судалгаа шинжилгээний ажил улсын салбарын засаглалыг сайжруулах чиглэлд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагаас дурдвал: а) МХХТ-ийг ашиглан төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлэх (Ухаалаг засаг төсөл); б) хөдөө орон нутагт тэргүүлэх чиглэлийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд засаглал ба олон нийтийн оролцоог сайжруулах (Тогтвортой амьжиргаа - 3 төсөл, мөн түүний үргэлжлэл); в) Төрийн санхүүгийн удирдлагыг бэхжүүлэх (Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл) болон жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, төсвийн ил тод байдал, иргэдийн төсөв зэрэг энэ чиглэлийн шинэлэг санаачилгуудыг дэмжих (ЕХ-ны итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй Монгол дахь засаглалыг бэхжүүлэх төсөл); г) эгэх хариуцлагаар дамжуулан олон нийтийн шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоо болон үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх (ШХА-ийн санхүүжилттэй МУНЭХБ төсөл). Засаглалын чиглэлийн зарим сул талуудыг илүү сайн олж мэдэхэд саяхан хийсэн авлигын эсрэг үйл ажиллагааны болон төрийн албаны шинэчлэлийн талаарх судалгаа шинжилгээний ажлууд тус нэмэр болох болно. Түүнчлэн, Засгийн газар шинэчлэлийг тууштай хэрэгжүүлэх эрмэлзэлтэй хэвээр бол Банкны зүгээс төрийн албаны шинэчлэлийн үйл явцад оролцоход бэлэн. ДБГ нь Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачилга (StAR)-аар дамжуулан санхүүгийн мөрдөн байцаалт, мөнгө угаахтай тэмцэх журам, зохицуулалт дээр зөвлөгөө өгч, чадавх бэхжүүлэх дэмжлэг үзүүлж байна.

#### **Нөлөөлөлд тэсвэртэй /резилент/ байдал**

**55. Нөлөөлөлд тэсвэртэй байдал гэдэг нь ДБГ-ын КОВИД-19 цар тахлын нөлөөллөөс "илүү сайн болох", ДБГ-ын арга хэмжээг урт хугацаандаа, тогтвортой нөлөөллийг бий болгоход чиглэсэн салбар дундын сэдэв юм.** ДБГ-ын оролцоо нь эдийн засгийн бодлого, бүтээмж өндөр салбар, хүний хөгжил, байгаль орчин, уур амьсгалын асуудалтай холбоотой эсэхээс үл хамааран нөлөөлөлд тэсвэртэй байх нь үйл ажиллагааны зарчмын нэг хэсэг байх ёстой. Эдийн засгийн чиглэлийн бодлого, институц нь эдийн засгийн тодорхойгүй байдал, ирээдүйн хямралд хариу арга хэмжээ авах төсвийн орон зайг бий болгох шаардлагатай. Бүтээмж өндөртэй салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхдээ хөрөнгө, ажилчид, бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг шийдвэрлэх шаардлагатай болно. Дэд бүтцийг хөгжүүлэхэд ирээдүйн аюулыг тодорхойлох үүднээс стандартыг сайжруулах, цахим холболтыг оновчтой болгож, КОВИД-19 цар тахлын дараах тэгш хүртээмжтэй байдлыг хангах шаардлагатай. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал зэрэг нэн чухал

<sup>31</sup> Тухайлбал, 2017 оны Нээлттэй төсвийн индекс (ОБИ) -д Монгол Улс 2015 онд 51 (100 онооноос) оноо авч байсан бол 2017 онд 46 болж үзүүлэлт буурсан орнуудын тоонд орсон. 2017 оны Трансперенси Интернешнл байгууллагын Авлигын төсөөллийн индексээр Монгол улс 103-т (жагсаалтын сүүлийн хагаст) орсон нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа хүлээгдэж байсан шиг үр дүнтэй байсангүйг илтгэж байна. 2016 онд Азийн сангаас гаргасан Монгол улсад Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаанаас (STOPP) үзэхэд иргэдийн янз бүрийн төрийн байгууллагад итгэх итгэл огцом буурсан явдал ажиглагдаж байна.

үйлчилгээг үзүүлэхэд ирээдүйн цочролоос хамгаалах арга замыг ч мөн харгалзан үзэх хэрэгтэй. Уур амьсгалын өөрчлөлтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тогтвортой байлгаж, эдийн засгийн сэргэлтийг хийх шаардлагатай. Эцэст нь ирээдүйн цочролд хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэхийн тулд ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлж, ядуурлаас гарах боломжийг тогтвортой хангах хэрэгтэй.

**56. Жендэрийн тэгш байдал нь тогтвортой нийгмийн чухал хэсэг юм.** Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг дэмжих тэргүүлэх чиглэлд бага боловсролын чанарыг сайжруулах, эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломж, эмэгтэй удирдагчтай бизнесийг өсгөх, тэтгэврийн насны хүйсийн ялгааг арилгах, орон нутгийн төлөвлөлт, төрийн бодлого боловсруулах эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг т нэвтрүүлэх үндэсний чадавхийг сайжруулах, жендэрийн тэгш байдлын Үндэсний хорооны мэдлэг, чадавхыг бэхжүүлэх зэрэг болно. ДБГ-ын хөрөнгө оруулалтын зээлийн хөтөлбөр, үнэлгээ шинжилгээний зөвлөх үйлчилгээ нь эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд түлхэц өгч байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэхэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, Экспортыг дэмжих төсөл, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл, мөн ОУСК-ийн зүгээс хувийн хэвшилтэй хамтран ажиллах зэрэг үйл ажиллагааг дурьдаж болно.

### **3.4 Түншлэлийн стратегийг хэрэгжүүлэх**

#### **3.4.1 Санхүүжилтийн хэмжээ ба төрлүүд**

**57. Энэхүү ТС-ийн хугацаанд Монгол Улс нь анх удаа зөвхөн ОУСБХБ-ны эх үүсвэрээс санхүүжинэ.** Монгол Улс ОУСБХБ -ны эх үүсвэрээс 2021-2025 оны санхүүгийн жилд санхүүжилт хүсэж болох хэмжээ нь одоогоор 400-500 сая ам.доллар байна. Энэхүү ТСХ-ийн хугацаанд ОУСБХБ -аас олгох бодит зээлийн хэмжээ нь улс орны эрэлт, нийт гүйцэтгэл, дэлхийн эдийн засаг болон санхүүгийн байдал, ОУСБХБ-ны санхүүгийн чадавх, Банкны бусад зээлдэгчдийн эрэлтээс хамаарна. Түүнчлэн, Монгол Улсыг КОВИД-19 цар тахалтай холбоотой яаралтай хариу арга хэмжээ авахад нь туслах зорилгоор 2020 оны 4 дүгээр сард Захирлуудын Зөвлөлөөс Монгол Улсад 2021 онд ОУХА-ын 19 дэх үдаагийн хуваарилалтаас Хямралын эсрэг хариу арга хэмжээ авах хөтөлбөр (CRW)-т түр хугацаагаар хамрагдах эрхийг, Гүйцэтгэлд суурилсан хуваарилалт (РВА)-аас ногдсонтой адил дүнгээр 2020 оны санхүүгийн жилд 50.7 сая ам.доллар олгосон. ОУХА-ын энэхүү тусгай хуваарилалтыг вакцины санхүүжилтийг дэмжих зэрэг КОВИД-19 цар тахлын эсрэг яаралтай хариу арга хэмжээ авах, эрүүл мэндийн системийн бэлэн байдал төслийн нэмэлт санхүүжилтэд ашиглах юм.

**58. ДБГ нь зээлийн янз бүрийн хэлбэрүүдийг ашиглах боломжийг судлах болно.** Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт (ХОТС) нь үндсэн зээлийн хэлбэр бөгөөд цаашид ч энэ хэвээр ба Монгол Улс нь Хөгжлийн бодлогын үйл ажиллагаа (ХБҮА)-ны зээлийг 2018 оны санхүүгийн жилд авсан ба хоёр үе шаттай хэрэгжүүлсэн. Шинэ ХБҮА боловсруулахаар төлөвлөж байгаа ба цаашид хэрхэн хэрэгжүүлэн нь тодорхой хүчин зүйлээс шалтгаалах болно. Банк болон Монголын эрх баригчид Үр дүнд суурилсан хөтөлбөр (P4R) хэрэгслийг ашиглах талаар мөн ярилцаж байсан бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн дараагийн үе шатыг хэрэгжүүлэхэд P4R ашиглах боломжтой талаар ярилцан цааш судлахаар төлөвлөж байна. Хэрэглэх боломжит нөхцөл үүссэн тохиолдолд ДБГ нь баталгааг хэрхэн ашиглахыг судалж үзэх болно.

**59. Банкны хязгаарлагдмал нөөцийг нэмэгдүүлэхийн тулд бусад түншүүдтэй хамтран санхүүжүүлэх боломжийг идэвхтэй эрэлхийлэх болно.** Банк нь өмнө нь Япон, БНСУ зэрэг түншүүдтэй хамтран хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж байсан. Саяхан Монгол Улсын

эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ОУВС, АХБ, Япон, БНХАУ болон БНСУ-тай хамтран Монгол Улсад дэмжлэг үзүүлсэн. Одоогийн хэрэгжиж байгаа төслүүдэд ШХА болон Сэргээгдэх эрчим хүчний төслийн дэмжих сангуудаас хамтран санхүүжилттэй хэрэгжиж байгаа 2 төсөл байна. Банк нь олон талт болон хоёр талын түншүүдтэй хэрхэн хамтрах, ялангуяа санхүүжилтийн хэрэгцээ ихтэй салбарт төсөл хамтран санхүүжүүлэх боломжийг хайн ажиллана. Мөн уур амьсгалын өөр өөр санхүүжилтийн эх үүсвэрийг судалж, уур амьсгалын холбогдолтой салбарын судалгааны ажилд нэмэлт буцалтгүй тусламж үзүүлж болох юм.

**60. Түүнчлэн, Банк нь стратегийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж, дүн шинжилгээ хийх ажлыг үргэлжлүүлнэ.** Ихэнх зөвлөх үйлчилгээ, дүн шинжилгээ нь тодорхой салбаруудад хэрэгжиж буй болон шинээр хэрэгжүүлэх зээлийн үйл ажиллагаатай уялдаатай байх боловч бусад зөвлөх үйлчилгээ, дүн шинжилгээ нь Банкны аливаа санхүүжилтээс хараат бус байж болох бөгөөд Монголын түншүүдийн бодлого, санхүүжилтийн шийдвэрийг дэмжих зэрэгцээ арга хэрэгсэл болж болох юм. Энэхүү нэмэлт зөвлөх үйлчилгээ, дүн шинжилгээ нь бусад хоёр болон олон талт түншүүд, мөн хувийн хэвшлийн санхүүжилтийг ашиглан нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэх хэрэгсэл болж болно. Зөвлөх үйлчилгээ, дүн шинжилгээ нь богино хугацааны бодлогын зөвлөгөө, техникийн туслалцаа, мөн саяхан хийсэн ЭЗХЗТ, Дэд бүтцийн салбарын үнэлгээ зэрэг урт хугацааны дүн шинжилгээний холимог хэлбэрээр байх болно.

**61. ОУСК нь өөрийн хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээний хэрэгслийг ашиглан Монгол Улсад хувийн хэвшлийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэхийг зорино.** ОУСК нь Монголын бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадвар, байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, чанартай гадаадын шууд хөрөнгө оруулалт, түншүүдийг татах, ЖДҮ эрхлэгчдэд зориулсан санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх, бүс нутгийн интеграцад нэгдэх бодлогын шинэчлэлийг дэмжихэд зориулан хөрөнгө оруулалт, зөвлөгөө өгөх үйлчилгээний хамрах хүрээгээ тэлж ажиллах болно. ОУСК-ийн 3.0 зорилтын хүрээнд банк болон бусад хандивлагч байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, Монгол Улсыг шинэ зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. ОУСК нь хувийн хэвшлийн санхүүжилтийн эх үүсвэрээр хийх боломжтой дэд бүтцийг салбарын төслүүдийг судалж дэмжинэ. Ингэснээр Засгийн газарт ирэх төсвийн дарамтыг арилгах, нийгмийн нэн шаардлагатай салбарт нөөцөө байршуулах боломжийг олгоно. (Жишээ нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал зэрэг). ОУСК нь Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хандивлагч болон бусад байгууллагуудын үзүүлж буй санхүүгийн болон техникийн туслалцааг түшиглэн, хамтран ажиллахыг эрмэлзэнэ. Дэд бүтцийн салбарт (эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, тээвэрлэх) шууд санхүүжилт хийх, ТХХТ хэрэгжүүлэх, хувьчлал явуулах зэрэг боломжууд байж болох ба ба ОУСК-ийн Хөрөнгө оруулах боломжтой төслүүдийг хөгжүүлэх хөтөлбөр (Upstream) болон Зах зээлийг хөгжүүлэх зөвлөгөө өгөх (CMAW) хөтөлбөрүүдийг хөрөнгө оруулах боломжтой төслүүд болон зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр ашиглаж болох юм.

**62. ОУСК-аас ОТ-н зэс, алтны уурхайг санхүүжүүлснээр Монгол Улс ОУСК-ийн хамгийн өндөр дүнтэй хөрөнгө оруулсан улсын нэг болсон.** 2020 оны 10 дугаар сарын байдлаар Монгол Улсад ОУСК-ийн өөрийн хөрөнгө оруулалтын багцаас 526 сая ам.доллар, бусад байгууллагуудаас 840 сая ам.доллар төвлөрүүлжээ. Үүнд ОТ төсөл 400 сая, 821 сая ам.долларыг тус бүр эзэлж байна. Мөн арилжааны банк, орон сууц, аялал жуулчлалын үйлчилгээ зэрэг бусад салбаруудад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн. Монгол Улсын өсөлтөд чухал хувь нэмэр оруулагч тул ОТ төслийг ОУСК ТСХ-г хэрэгжих хугацаанд үргэлжлүүлэн дэмжих болно. Үүнд, ОТ төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлж, үүний дотор ЖДҮ ба уурхайн уялдаа холбоо, уул уурхайн салбарын үйл

ажиллагаанд шаардлагатай ус, сэргээгдэх эрчим хүч, орон нутгийн хөгжил зэрэг чиглэлд үргэлжлүүлэн ажиллана. ОУСК-иас ОТ төсөлд нэмэлт санхүүжилт олгох эсэх нь санхүүжилтийн хэрэгцээ, улс төрийн тогтвортой байдал, макро эдийн засгийн нөхцөл байдал зэргээс хамаарна. ТСХ-ийн хугацаанд ОУСК-ийн бусад тэргүүлэх чиглэлүүдэд санхүүгийн хүртээмжтэй байдлын сайжруулж улмаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх (ялангуяа ногоон санхүүжилт, ЖДҮ ба эмэгтэйчүүдийн өмчит ЖДҮ-ийн чиглэлээр), хөдөө аж ахуй, аялал жуулчлал, байгальд ээлтэй дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг орно. Монгол Улсын эдийн засгийн шинэчлэлийн хурд, хөрөнгө оруулалтын орчин эдийн засгийн тогтвортой байдлаас хамаарч ОУСК-ийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь 100 сая ам.доллараас 800 сая ам.доллар хүртэл (ОУСК-ийн өөрийн хөрөнгө болон бусад хамтрагчийн хөрөнгө) байх боломжтой.

**63. ОУСК нь одоогоор дөрвөн төслөөр дамжуулан зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд эдгээрийг ТСХ-ний хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно.** ОУСК нь худалдаа, экспортыг хөнгөвчлөх, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтыг дэмжих, уул уурхай дахь усны менежмент, төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрхзүйн орчны шинэчлэл, өртгийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр (2020 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар) нийтдээ 5.1 сая ам.долларын төсөв бүхий зөвлөгөө өгөх төслүүдийг ОУСК-аас хэрэгжүүлж байна. ОУСК нь цаашид зөвлөгөө өгөх үйлчилгээгээ өргөжүүлэх ба ногоон санхүүжилт (ногоон бонд, ногоон байгууламж), санхүүгийн салбарт байгаль орчин, нийгэм, засаглалын шаардлагуудыг нэвтрүүлэх, ЖДҮ-ийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх хүртээмж, зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний санхүүжилт зэрэг чиглэлээр ажиллах болно. ОУСК нь хамтран ажилладаг түншлэгч банкуудтай компанийн засаглал, эрсдэлийн удирдлага (МУ болон ТСТ-тэй холбоотой эрсдэл багтсан болно), тогтвортой эрчим хүчний санхүүжилт, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд цахим шийдлүүдийг нэвтрүүлэх зэрэг чиглэлээр үргэлжлүүлэн хамтран ажиллах болно. ОУСК нь саяхан Засгийн газраас Бизнес эрхлэх шинэчлэлийг дэмжих, Хөрөнгө оруулагчдын хариу арга хэмжээ авах системчилсэн механизм (SIRM)-ыг үргэлжлүүлэх, ГШХО-ыг сурталчлах, дотоодын ЖДҮ эрхлэгчдийг шууд хөрөнгө оруулалтын компаниудтай харилцах нийлүүлэлтийн холболтуудыг хөгжүүлэх чиглэлээр хүсэлт хүлээн авсан.

**64. ОТХОБА-ын Монголд хэрэгжүүлсэн төсөл буюу ОТ уурхайн төслийг хөгжүүлэхэд гаргасан баталгаа нь Зүүн өмнөд Ази, номхон далайн бүс нутагтаа хамгийн том нь билээ. Уг баталгаа 858 сая ам.долларын (2020 оны санхүүгийн жилийн байдлаар) дүнтэй бөгөөд Монгол Улс ОТХОБА-ын багц дахь хамгийн том 10 орны нэгд тооцогдож, нийт олгосон баталгааны 4 хувийг эзэлж байна.** ОТХОБА-ын тэргүүлэх чиглэл нь ОУХА-аас дэмжлэг авах шаардлага хангасан орнуудын хөрөнгө оруулалтыг дэмжих бөгөөд Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн салбарыг дэмжихэд гадаадын хувийн санхүүжилтийг төвлөрүүлэхэд хувь нэмрээ оруулсан.<sup>32</sup> Тус баталгаа нь 12 жилийн хугацаатай (2015-2027) бөгөөд өмчлөлийн эрсдэл, шилжүүлгийн хязгаарлалт ба хөрвөх чадваргүй болох эрсдэл, дайн ба иргэний үймээн самуун, гэрээг зөрчих зэрэг эрсдэлээс хамгаална. ОТХОБА нь цаашид дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүч зэрэг голлох салбаруудад хил дамнасан хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлж, Банк, ОУСК-тай нягт уялдаатай ажиллах болно.

**65. ДБГ-ын байгууллагууд Монгол Улсад хувийн хөрөнгө оруулалтыг татах, ялангуяа дэд бүтэц, уул уурхайн салбаруудад хувийн хөрөнгө оруулалтыг татах боломжийг нээх чиглэлээр**

---

<sup>32</sup> Батлан даалт гаргах үед Монгол Улс ОУХБ-ын гишүүн улс байв.

**ажиллаж байна.** Уул уурхайн салбарт ДБГ Монгол улстай урт удаан хугацаанд хамтран ажиллаж байна. ОУСК нь ОТ уурхайд томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын зээлийг олгож, ОТХОБА нь арилжааны санхүүжилтийг авах боломжийг нээх зорилгоор улс төрийн эрсдэлийн баталгааг гаргаж, харин Дэлхийн Банк уул уурхайн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ялангуяа төсөв, макро эдийн засгийн удирдлагын чиглэлээр техникийн туслалцаа үзүүлсэн. ДБГ-ын шинэ арга хэмжээнүүд нь хувийн хэвшлээс нэмэлт нөөцийг төвлөрүүлэх боломжийг авч үзэх болно. Дэд бүтцийн салбарын үнэлгээ (InfraSAP) судалгаанд үндэслэн төлөвлөсөн Монголын тээврийн холболт ба ложистикийг сайжруулах төсөл нь дэд бүтцийн чухал төслүүдэд хувийн хэвшлийн оролцоог хангах боломжийг олгоно. Үүний нэгэн адил төлөвлөж буй Хотын өрсөлдөх чадварын төсөл нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн Банк нь ОУСК-тай хамтран мал аж ахуй, аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтын боломжуудыг тодорхойлох, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлж байна.

#### IV. ТСХ-НИЙ ХӨТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ

66. **Хөтөлбөрт учирч болох эрсдэл ерөнхийдөө их байна.** Үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх системчилсэн хэрэгсэл (SORT)<sup>33</sup>-д үндэслэн макро эдийн засаг, улс төр, засаглалаас гадна байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг гол эрсдэлүүд хэмээн тодорхойллоо.

**Хүснэгт 6: Эрсдэлийн хураангуй (Н: Өндөр; S: Их; М: Дунд; L: Бага)**

Эрсдэлийн төрөл	Үнэлгээ
1. Улс төр ба засаглал	S
2. Макро эдийн засаг	H
3. Салбарын стратеги ба бодлого	M
4. Төсөл, хөтөлбөрийн техникийн зураг төсөл	M
5. Хэрэгжүүлэлт ба тогтвортой байдлыг хангах институцийн чадавх	S
6. Үүргийн биелэлт	S
7. Байгаль орчин ба нийгэм	S
8. Оролцогч талууд	M
<b>Нийт</b>	<b>S</b>

67. **Макро эдийн засгийн эрсдэл өндөр хэвээр байх төлөвтэй.** Монгол Улсын эдийн засгийн тогтворгүй байдал болон КОВИД-19 цар тахлын нөлөөллөөс харахад ТСХ-г хэрэгжүүлэх хугацаанд макро эдийн засгийн нөхцөл байдал тогтворгүй хэвээр байх төлөвтэй. Түүнчлэн улс орны өрийн нөхцөл байдал хүндрэлтэй хэвээр байх бөгөөд өрийн удирдлагыг анхаарал болгоомжтой хэрэгжүүлэх хэрэгтэй болно. Макро эдийн засгийн менежментийг дэмжих нь ТСХ-ний гол зорилго юм. Макро эдийн засгийн эрсдэлийг бууруулахын тулд Монгол Улсын Засгийн газар КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээг анхааралтай удирдаж, шинэчлэлийн чиг шугамыг баримтлах нь нэн чухал байх болно. Түүнчлэн томоохон хөрөнгө оруулалтын гэрээний дагуу

<sup>33</sup> Эрсдэлийн тодорхойлолт ба үнэлгээний гарын авлагыг дараахь хаягаар авах боломжтой SORT түр гарын авлагын тэмдэглэлд оруулсан болно.

[http://www.worldbank.org/content/dam/Worldbank/document/SORT\\_Guidance\\_Note\\_11\\_7\\_14.pdf](http://www.worldbank.org/content/dam/Worldbank/document/SORT_Guidance_Note_11_7_14.pdf).

хүлээсэн үүргээ биелүүлэх нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтын орчинг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

68. **Улс төр, засаглалын эрсдэл их өндөр байна.** Өмнө хэрэгжүүлсэн ТС-ийн хугацаанд эдгээр эрсдэл бодитой бий болсон бөгөөд цаашид ч хэвээр үлдэх хандлагатай байна. Үүнд: Засгийн газар, төрийн албаны байнгын өөрчлөлтийн улмаас төслийн хэрэгжилт удаашрахаас гадна банкнаас шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийг төлөвлөх шатанд Засгийн газрын байгууллагатай хамтран ажиллахад хүндрэлтэй байдаг, мөн хэрэгжиж буй төслийн үйл ажиллагаанд улс төрийн оролцоо нөлөөлдөг зэрэг асуудлууд багтана. Ийнхүү хөндлөнгөөс оролцох нь төслийг хэрэгжүүлэх чадавх, тогтвортой байдалд нөлөөлнө. Мөн 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Засгийн газраас эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэх амлалтаа биелүүлэхэд эрсдэл үүсч болох юм. ДБГ-ын Монгол улсыг хариуцсан нэгж нь нөхцөл байдлыг анхааралтай хянаж, тус улстай яриа хэлэлцээг тохируулан хийж, төсөл хэрэгжүүлэхэд улс төрийн хөндлөнгийн оролцооноос болгоомжилж хянуур байх болно.

69. **Хэрэгжилтийг хангах институцийн чадавх ба тогтвортой байдлын эрсдэл өндөр хэвээр байна.** Хэдийгээр хууль эрхзүйн зохицуулалтууд зохистой хэмжээнд байгаа хэдий ч улс төрийн өсөн нэмэгдэх дарамт шахалтаас шалтгаалан институцийн зохицуулалтуудын хэрэгжилт хангалтгүй байгаа нь гол сорилт болсоор байна. Энэ нь өнгөрсөн хугацаанд ДБГ-ын дэмжлэгт нөлөөлж байсан. Уг хэрэгжилтийн хоцрогдлыг бууруулах нэг арга хэмжээ нь хараат бус хяналтын механизмыг бэхжүүлэх (тухайлбал төсвийн бодлогын хувьд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэх мэт) эсвэл төрийн албыг сайжруулах явдал юм. Татварын шинэчлэл, төсвийн хөрөнгө оруулалтад хийх өөрчлөлтүүд, нийгмийн хамгаалал, тэтгэврийн шинэчлэл, бизнес ба хөрөнгө оруулалтын орчны шинэчлэл зэрэг гол чиглэлүүдэд төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх мөн судалгаа шинжилгээ хийх нь хэрэгжилтийн эрсдэлийг бууруулж, Түншлэлийн Стратегийг хэрэгжүүлэх хугацаанд шинэчлэл хийх боломжуудыг алдалгүй тогтвортой хадгалахад туслах болно.

70. **Худалдан авалт, санхүүгийн удирдлагын эрсдэл өндөр хэвээр байна.** Дэлхийн Банкны төслийн нийт багцын хувьдсан хүүгийн удирдлагын гүйцэтгэлийг хангалттай гэж үзсэн. Сүүлийн жилүүдэд зарцуулахыг зөвшөөрөөгүй зардал гаргасан эсвэл Шударга байдлын дэд ерөнхийлөгчийн газар (энэ нь Дэлхийн Банк Группын хараат бус нэгж юм)-аас мөрдөн шалгалттай хийсэн тохиолдол гараагүй. Гэсэн хэдий ч Монгол Улсад хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн удирдлагын чадавхыг улам бүр сайжруулах шаардлага байсаар байна. Банк төслүүдийн тусгай дансыг Төрийн сангийн системд шилжүүлэх шийдвэрийг зөвшөөрөх шатандаа байна. Уг үйл ажиллагаанд Банкны зүгээс дэмжлэг үзүүлэхдээ Төрийн сангийн тогтолцоог бэхжүүлэх мөн хөрөнгийн удирдлага, ашиглалтыг сайтар хянаж, зохих хяналтыг хэвээр хадгалахад анхаарах болно. Түүнчлэн, Банк нь банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжиж буй төслүүдийн жилийн санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэх хараат бус хувийн аудитын байгууллагуудыг сонгон шалгаруулах, гэрээлэх үйл явцын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр Үндэсний Аудитын Газартай үргэлжлүүлэн хамтран ажиллах болно.

71. **Бусад томоохон эрсдэлүүдэд байгаль орчны болон нийгмийн хамгааллын эрсдэл багтана.** Өнгөрсөн хугацаанд уул уурхай, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын чиглэлд хэрэгжиж байсан төслийн нөлөөлөлд өртсөн иргэдээс нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн талаар гомдол гарч байсан. Банкны зүгээс энэ чиглэлд хэрэгжүүлэх үйл ажиллагаа өргөжих тусам эрсдэл илүү өндөрсөж байна. Иймд ДБГ-ын дүрэм журмыг үргэлжлүүлэн дагаж мөрдөх, ялангуяа Монгол Улсад шинээр амжилттай нэвтрүүлсэн ДБГ-ын Байгаль орчин, нийгмийн удирдамжийг нягт дагаж мөрдөх шаардлагатай байна. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулахад нөлөөлөлд өртөж

болзошгүй ард иргэдтэй уулзаж зөвлөлдөх нь чухал болохыг өнгөрсөн туршлагууд нотлон харуулсан юм.